

**“ШҮҮХЭД ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ ГАРГАХ, ТҮҮНИЙГ ҮНЭЛЭХ АСУУДАЛ”  
БОДЛОГЫН СУДАЛГАА**

*Шүүхийн судалгаа мэдээлэл, сургалтын хүрээлэн*

**2015 он**

## Гарчиг

### Удиртгал

**Нэгдүгээр бүлэг. Монгол Улсын шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцоо, эрх зүйн орчин**

- 1.1. Шүүхийн шинжилгээний тухай ойлголт, эрх зүйн орчин
- 1.2. Шүүхийн шинжилгээний төрөл, ангилал
- 1.3. Шинжээчийн дүгнэлт, түүнийг үнэлэх асуудал
- 1.4. Шүүхэд шинжээчийн дүгнэлт гаргаж буй этгээдүүд, тэдгээрийн чиг үүрэг

**Хоёрдугаар бүлэг. Шүүхэд шинжээчийн дүгнэлт гаргаж буй практик, тулгамдаж буй асуудал**

- 2.1. Эрүүгийн хэрэгт шинжээчийн дүгнэлт гаргаж буй практик, тулгамдаж буй асуудал
- 2.2. Иргэний хэрэгт шинжээчийн дүгнэлт гаргаж буй практик, тулгамдаж буй асуудал
- 2.3. Захиргааны хэрэгт шинжээчийн дүгнэлт гаргаж буй практик, тулгамдаж буй асуудал

**Гуравдугаар бүлэг. Гадаад улс орны туршлага**

- 3.1. ХБНГУ-ын шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцоо, эрх зүйн орчин
- 3.2. ОХУ-ын шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцоо, эрх зүйн орчин
- 3.3. БНСУ-ын шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцоо, эрх зүйн орчин
- 3.4. Эстон Улсын шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцоо, эрх зүйн орчин

### Дүгнэлт

### Санал, зөвлөмж

### Эх сурвалж

## Удиртгал

Шүүхийн судалгаа мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн 2015 оны бодлогын судалгаа төлөвлөгөөний дагуу “Шүүхэд шинжээчийн дүгнэлт гаргах, түүнийг үнэлэх асуудал” сэдэвт бодлогын судалгааг 3 дугаар улиралд хийж гүйцэтгэлээ. Судалгааны багт ШСМСХ-ийн шүүхийн судалгаа, сургалт хариуцсан референт Х.Билгүнзаяа, туслах судлаач Ж.Ганзориг, гэрээт судлаачдаар Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Д.Очмандах, Чингэлтэй, Баянзүрх, Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Э.Энэбиш, Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.Адъяасүрэн, Хууль сахиулахын их сургуулийн тэнхимийн эрхлэгч, доктор Б.Даваа нар хамтран ажиллаа.

Энэ бодлогын судалгааны ажилд сүүлийн 3 жилийн байдлаар эрүү, иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шинжээч ямар төрлийн шинжилгээ хийж байгааг хэрэг, маргааны төрөл тус бүрээр түүвэрлэн судалсан. Мөн эрүү, иргэн, захиргааны хэрэгт гол төлөв ямар төрлийн хэрэг, маргаанд шинжээч томилж байгааг тодорхойлж, шинжилгээний төрлийг нь судлав. Түүнчлэн Монгол Улсыг шүүхийн шинжилгээ хийж байгаа байгууллагын бүтэц, тогтолцоо, эрх зүйн орчинг боловсронгуй болгох зорилгоор ОХУ, БНСУ, Герман, Эстон зэрэг улсын шүүхийн шинжилгээний тогтолцоо, шинжилгээний төрөл, эрх зүйн орчинг харьцуулан судалсан болно.

**Судалгааны ажлын зорилго:** Тус бодлогын судалгаагаар шүүхийн шинжилгээний тухай ойлголт, эрх зүйн зохицуулалт, шүүхийн шинжилгээний төрөл, ангилал болон эрүү, иргэн, захиргааны хэрэгт шинжээчийн дүгнэлт гаргаж байгаа практик, тулгамдаж буй асуудлыг тодорхойлон шүүхэд шинжээчийн дүгнэлт гаргаж буй өнөөгийн практикийг сайжруулах санал, зөвлөмж боловсруулахад оршино. Энэхүү зорилгыг хангах үүднээс дараах зорилтыг дэвшүүлэн ажиллаа. Үүнд:

1. Шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцоо эрх зүйн орчинг судлах:
  - Шүүхийн шинжилгээний тухай ойлголт;
  - Шүүхийн шинжилгээний эрх зүйн орчин;
  - Шүүхийн шинжилгээний төрөл, ангилал;
  - Шинжээчийн дүгнэлт гаргаж буй этгээдүүд, тэдгээрийн чиг үүрэг, хараат бус байдлын баталгаа;
2. Шүүхээс шинжээчийн дүгнэлт гаргуулах, түүнийг үнэлэх практикийг судлах:
  - Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь шинжээчийн дүгнэлт, практикийг судалж, тулгамдаж буй асуудлыг тодорхойлох;
  - Эрүү, иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шинжээч ямар төрлийн шинжилгээ хийж байгааг хэрэг, маргааны төрөл тус бүрээр тодорхойлох (түүвэрлэн судлах);
  - Шинжээчийн дүгнэлт гаргуулахаар хэргийн оролцогчдын зүгээс ямар хүсэлт гаргаж байгаа, уг хүсэлтийг хэрхэн шийдвэрлэсэн байдлыг судлах;
3. Гадаад улс орны туршлагыг судлах:
  - ХБНГУ, БНСУ, ОХУ, Эстон зэрэг улсын шүүхийн шинжилгээ хийдэг байгууллагуудын бүтэц, тогтолцоог Монгол Улсын шүүхийн шинжилгээ хийдэг байгууллагын бүтэц, тогтолцоотой харьцуулан судлах зэрэг болно.

**Судлагдсан байдал:** Шүүхийн шинжилгээ хийх нь маш нарийн, төвөгтэй ажиллагаа байдаг бөгөөд энэ үүднээс энэ тогтолцоог боловсронгуй болгох салбарын эрдэмтэн судлаачдын ном, өгүүлэл, нийтлэл, нэг сэдэвт бүтээл цөөнгүй хэвлэгдэн нийтлэгдсэн байдаг. Тухайлбал, ХСИС-ийн тэргүүн дэд захирал, цагдаагийн хурандаа Б.Бат-Эрдэнэ, докторант Т.Очирбатын “Шинжлэн магадлахуй” бүтээл, Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс гаргасан “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь шинжилгээ” сургалтын гарын авлага зэрэг нэг сэдэвт болон хамтын бүтээлүүд хэвлэгдэн гарсан байна.

**Судалгааны арга зүй:** Судалгаанд шинжлэх ухааны танин мэдэхүйн нийтлэг аргуудаас гадна шүүхэд шинжээчийн дүгнэлт гаргаж буй практикийг судлахдаа санал асуулга, статистик болон ярилцлагын аргууд, гадаад орнуудын сайн туршлагыг судлахдаа харьцуулан судлах аргыг тус тус ашигласан болно.

**Судалгааны ажлын шинэлэг тал:** Энэ бодлогын судалгааны ажлын хүрээнд шүүхэд шинжээчийн дүгнэлт гаргаж байгаа байгууллагын тогтолцоо, олон улсын болон дотоодын эрх зүйн хэм хэмжээг судалснаас гадна дараах асуудлыг авч үзсэн болно. Үүнд:

1. Шүүхэд шинжээчийн дүгнэлт гаргаж буй шүүхийн практикийг судалсан. Энэ асуудлын хүрээнд:
  - Сүүлийн 3 жилийн байдлаар шүүхээс хянан шийдвэрлэсэн эрүү, иргэн, захиргааны хэргээс шинжээч томилсон тогтоол, шинжээчийн дүгнэлтийг ангилан судалсан(түүвэр судалгаа хийсэн);
  - Хөдөө орон нутгийн шүүхээр шийдвэрлэсэн хэргүүдийг мөн авч үзсэн. (Үүнд: Сэлэнгэ, Орхон, Дархан-Уул аймгийн шүүхүүдийг хамруулсан).
2. Эрх зүйн орчинг сайжруулах, тулгамдаж буй асуудлыг тодорхойлох зорилгоор шүүгчдийн дунд санал асуулга, хэлэлцүүлэг хийсэн.
3. Гадаад орнуудын шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцоо, эрх зүйн орчинг судалж, дотоодын хууль, эрх зүйн орчинг сайжруулах талаар санал, зөвлөмж дэвшүүлсэн болно.

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН ТОГТОЛЦОО, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

### 1.1. Шүүхийн шинжилгээний тухай ойлголт, эрх зүйн орчин

Шүүхээс хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд хууль, эрх зүйгээс гадна өөр салбарын мэдлэгийг ашиглан үнэлэлт, дүгнэлт өгөх шаардлага гардаг. Эрүү, иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны буюу процессын хуулиудад шинжээчийн дүгнэлт нь хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий баримт сэлт, мэдээллийг тогтооход хэрэглэх нэг баримт болохыг заасан байдаг. Шүүхийн шинжилгээний тухай хуульд зааснаар шүүхийн шинжилгээ гэж “эрүү, иргэн, захиргааны болон бусад хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид заасан тусгай мэдлэг шаардсан асуудал /шинжлэх ухаан, техник, урлаг, соёл, нягтлан бодох бүртгэл зэрэг/-ыг шийдвэрлэхийн тулд шинжилгээний объектод шинжилгээ хийж дүгнэлт гаргах ажиллагааг”<sup>1</sup> хэлнэ гэжээ. Шүүхийн шинжилгээний гол зорилго нь хэрэгт ач холбогдолтой нөхцөл байдлыг шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоох явдал бөгөөд шинжилгээ нь үнэнийг танин мэдэх, бодит байдлыг тогтоох процессын нэмэлт боломж төдийгүй баримт сэлт, мэдээллийг шалгах, шинэ мэдээлэл олж авах хэрэгсэл болдог. Үүнтэй холбоотойгоор өнөөгийн шүүхийн практикт хэрэг, маргааны төрлөөс хамааран шинжилгээ хийлгэх шаардлага өсөн нэмэгдсээр байна.

**Шүүхэд шинжилгээ хийлгэх үндэслэл, журам:** Шүүхэд шинжилгээ хийлгэх нь хууль зүйн нарийн процесс ажиллагаа байдаг бөгөөд үүнийг гүйцэтгэхэд холбогдох хууль, дүрэм журмыг нарийн баримтлах шаардлагатай үүснэ. Шүүхэд шинжилгээ хийлгэх шаардлага нь тухайн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд хууль эрх, зүйгээс гадна тусгай салбарын мэдлэгийг ашиглах явдал байдаг бол шинжилгээ хийлгэх үндэслэл нь эрх бүхий этгээдийн гаргаж буй **шинжилгээ хийлгэх тогтоол** байна. Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд гэдэг нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч, шүүхийг болон хуульд заасан төрийн эрх бүхий байгууллагыг ойлгоно.<sup>2</sup> Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд шинжилгээ хийлгэх тогтоолдоо шинжилгээ хийлгэх үндэслэлийг тодорхой заасан байх ёстой бөгөөд шинжилгээг хэргийн нөхцөл байдлыг тогтооход тусгай мэдлэг шаардсан ямар ч асуудлаар хийлгэж болно. Харин хууль хэрэглэх, хуулийн зүйл, хэсэг заалтыг тайлбарлуулахаар шинжээч томилохыг хориглосон байдаг.<sup>3</sup> Мөн Эрүүгийн байцаан шийтгэх хууль (цаашид “ЭБШ хууль” гэх)-д заавал шинжээч томилж, шинжилгээ хийлгэх тохиолдлуудыг хуульчилсан байна. Үүнд:

- ✓ гадны нөлөөллөөр буюу сэжигтэй байдлаар нас барсан бол түүний шалтгааныг тогтоох;
- ✓ бие махбодид учирсан гэмтлийн зэрэг, шинж байдлыг тогтоох;
- ✓ сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч хэргийнхээ үйлдлийг тайлбарлах, түүнийг хариуцах чадвартай эсэхэд эргэлзээ төрвөл тэдний сэтгэцийн байдлыг тодорхойлох;
- ✓ гэрч, хохирогч нь хэрэгт ач холбогдол бүхий байдлыг бодитойгоор тусгаж, зөв мэдүүлэг өгөх чадвартай эсэхэд эргэлзээ төрвөл тэдний сэтгэцийн байдлыг тодорхойлох;

<sup>1</sup> Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалт., УБ., 2009 он.

<sup>2</sup> Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дахь заалт., УБ., 2009 он.

<sup>3</sup> Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 155 дугаар зүйлийн 155.5 дахь заалт., УБ., 2002 он.



- ✓ сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогчийн насны тухай баримт бичиг байхгүй бөгөөд тэдний насыг тогтоох явдал хэрэгт ач холбогдолтой байвал;
- ✓ онц хүнд гэмт хэргийн яллагдагчийн сэтгэцийн байдлыг тодорхойлох зэрэг тохиолдлууд оржээ.

Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд шинжилгээ хийлгэх тухай тогтоол, захирамж, хүсэлтэд шинжилгээ хийлгэх үндэслэл, шинжилгээ хийлгэх байгууллагын нэр, шинжилгээ хийх хугацаа, шинжээчид тавих асуулт, шинжилгээний объектийн талаарх мэдээллийг заавал тусгасан байна. Шинжилгээний зорилт биелэх эсэх нь шинжээчид тавьж буй асуултаас шууд хамааралтай байдаг. Иймд шинжээчид зөв, үндэслэлтэй асуулт тавих нь шинжилгээний үр дүн бодитой, үнэн зөв гарах нөхцөл болдог.<sup>4</sup> Практикт эрх бүхий байгууллага, албан тушаалтнуудаас шинжилгээ хийлгэхээр ирүүлсэн тогтоол, захирамжийн утга, агуулга нь шинжээчдэд ойлгомжгүй байх тохиолдол багагүй гардаг. Үүнээс үүдэн тавьсан асуултыг буруу ойлгох, улмаар шийдвэрлэж буй асуудлыг бүрэн шийдвэрлэхгүй байх явдал гарч байна гэсэн шүүмжлэл байна. Мөн шинжилгээ хийх объект буюу ул мөр, эд мөрийн баримтууд нь хуульд заасан үндэслэл журмын дагуу олж авсан байх ёстой бөгөөд хэрэв хууль бусаар олж авсан бол түүнд хийсэн шинжээчийн дүгнэлт нь онолын хувьд үндэслэлтэй байж болох хэдий ч хууль зүйн хувьд нотолгооны чадвараа алдах эрсдэлтэй болно.

**Шинжээч:** Шинжээч гэсэн үгийг үг зүйн тайлбар толинд **шинжлэгч**,<sup>5</sup> англиар **expert**<sup>6</sup> гэсэн байх ба Шүүхийн шинжилгээний тухай хууль, ЭБШ хууль болон холбогдох бусад процессын хуулиудад шинжилгээ хийлгэх субъектийг нэрлэн заагаагүй бөгөөд тусгай мэдлэг бүхий хэнийг ч шинжээчээр томилж болохоор заасан байна. Гэхдээ энэ нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор шүүгчийн үзэмжийн асуудал биш юм. Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд шинжээчийг томилохдоо тухайн этгээдийн мэргэжил, ажлын дадлага, туршлага зэргийг харгалзан үзэх шаардлагатай. Монгол Улсын ЭБШ хуульд зааснаар шинжилгээ хийлгэж, дүгнэлт гаргуулахын тулд зохих байгууллагын шинжээч, тусгай мэдлэг бүхий тухайн хэрэгт хувийн сонирхолгүй этгээдийг шинжээчээр хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх тогтоолоор, шүүгч захирамжаар томилно гэж заажээ.

Шинжилгээ хийлгэх тогтоол, захирамжид шинжилгээ хийхээр томилогдсон этгээд хуульд зааснаас бусад үндэслэлээр шинжилгээ хийхээс санаатайгаар зайлсхийх, татгалзахыг хориглоно. Харин шинжээч нь эрх бүхий этгээдээс тавигдсан асуулт нь өөрийн тусгай мэдлэгийн хүрээнээс хэтэрсэн, шинжилгээнд ирүүлсэн баримт сэлт нь дүгнэлт гаргахад дутагдалтай байна гэж үзвэл энэ тухай шинжилгээ хийлгэхээр даалгасан байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдэгдэнэ. Шинжээч шинжилгээний арга аргачлал, техник хэрэгслийг бүрэн дүүрэн ашиглаж, шинжилгээ хийж, шинж тэмдэг, мэдээллүүдийг тогтоосны үндсэн дээр түүнийг нэгтгэн дүгнэн тухайн шинжилгээ хийгдсэн асуудлын хүрээнд хамгийн туйлын байж болох төгс үр дүн, дүгнэлтэд хүрнэ. Товчоор хэлбэл, мэдлэг, дадлага, чадвар, шинжилгээний арга хэрэгслийг бүрэн дүүрэн төгс ашигласан байх ёстой. Шинжээч нь зөвхөн өөрт тавигдсан асуултууд бус гагцхүү бодит зүй тогтлоос шинжлэгдэн гарсан үйл

<sup>4</sup> Шинжээчид асуулт тавихдаа дараах зүйлийг анхаарах шаардлагатай. Үүнд:

- Асуултад хариулах боломжтой байх /өнөө үеийн шинжлэх ухаан хариулт өгөх боломжтой байх/;
- Хэрэгт ач холбогдолтой байх /нотолгоонд ач холбогдолтой/;
- Нэр томъёог ойлгомжтой, зөв ашиглах шаардлагатай.

<sup>5</sup> Я.Цэвэл, “Монгол хэлний товч тайлбар толь”, 849 дахь тал.

<sup>6</sup> Oxford Dictionary Monsudar

баримтыг дүгнэлтдээ бүрэн тусгах үүрэгтэй. Энэ талаар ЭБШ хуулийн 162 дугаар зүйлийн 162.3.-т “Шинжилгээ хийж байх үед шинжээч уг хэрэгт ач холбогдол бүхий бусад зүйлийг олж тогтоосон бол энэ талаар асуулт тавигдаагүй ч байсан өөрийнхөө дүгнэлтэд заах үүрэгтэй”. Мөн Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.5-д “Хэрэгт ач холбогдол бүхий шинэ нөхцөл байдлыг олж тогтоовол энэ талаар дүгнэлтдээ тусгах” үүрэгтэй гэж хуульчилж өгчээ.

**Шүүхийн шинжилгээний зарчим:** Шинжилгээ хийлгэхээр даалгасан албан тушаалтан шинжээчдээс шинжилгээ хийхтэй холбоотой ажиллагаанд заавал баримтлах зан үйлийг шинжилгээний зарчим гэж ойлгож болно. Шүүхийн шинжилгээний тухай хуульд зааснаар шүүхийн шинжилгээ хийхэд дараах зарчмыг баримтална. Үүнд:

- Хууль дээдлэх;<sup>7</sup>
- Хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;<sup>8</sup>
- Хараат бус байх;<sup>9</sup>
- Нууцыг хадгалах;
- Шинжилгээг тал бүрээс нь бүрэн, бодитой, шинжлэх ухааны үндэслэлтэй<sup>10</sup> хийх гэсэн зарчмыг баримтална гэж заажээ.

## 1.2. Шүүхийн шинжилгээний төрөл, ангилал

Шүүхээр хэрэг, зөрчил, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны цар хүрээ өргөжсөөр байгаа өнөөгийн нөхцөлд түүний нотлох ажиллагааны гол хэлбэрийн нэг болох шүүхийн шинжилгээний ач холбогдол, эрэлт хэрэгцээ өсөн нэмэгдсээр байна. Өөрөөр хэлбэл, шүүхийн шатны нотлох үйл ажиллагааг шинжлэх ухаан, техник технологийн хөгжил дэвшилд тулгуурлан хийх зарчмын шаардлага тулгамдсан зорилтын нэг болоод байна. Олон улсын жишгээс харахад шүүхийн шинжилгээг нийт 12-15 төрөлд ангилж байгаагаас тэдгээр нь дор бүрдээ 300-500 гаруй төрөл зүйлээр ялгагдаж байна. Эдгээрийн 30 хүрэхгүй хувь нь төрийн шүүхийн шинжилгээний байгууллагад хийгдэж байгаа бол үлдсэн хувь

<sup>7</sup> **Хууль дээдлэх зарчим:** Шинжилгээг зөвхөн хуульд заасан үндэслэл, журмын дагуу хийх бөгөөд хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж хийвэл тэрхүү шинжээчийн дүгнэлт нь нотлох баримтын эх сурвалж болж чадахгүй. Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалт. УБ., 2009 он.

<sup>8</sup> **Хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх:** Шинжлэн магадлахуй болон шинжилгээний арга, аргачлал нь хүний амь нас, эрүүл мэндэд аюулгүй, хууль ёсны ашиг сонирхол, эд хөрөнгөнд хохирол учруулахааргүй байхын зэрэгцээ шинжилгээ хийж байгаа эрх бүхий этгээд энэхүү зарчмын хэрэгжилтийг хангах үүрэгтэй. Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалт. УБ., 2009 он.


<sup>9</sup> **Хараат бус байх:** Шинжилгээ хийж, дүгнэлт гаргах үйл явц нь бие даасан, аливаа нөлөөллөөс хараат бус байх ёстой бөгөөд шинжилгээ хийж буй шинжээчид ямар нэгэн байдлаар нөлөөлбөл тухайн шинжилгээний үр дүн хэргийн бодит байдлаас өөрөөр буюу үнэн бодитой бус дүгнэлт гарна. Харин дадлага туршлагатай ахлах болон мэргэшсэн шинжээчийн зүгээс мэргэжил арга зүйн туслалцаа зөвлөмж өгч болох бөгөөд шууд дүгнэлтийн утга агуулгад нөлөөлөхүйц байдлаар зааварчилга, зөвлөмж өгч болохгүй, учир нь шинжилгээний явц, үр дүн, дүгнэлтийн үнэн бодитой байх асуудлыг Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн 85 дугаар зүйлийн 85.1, Шүүхийн Шинжилгээний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4-т заасны дагуу шинжээч өөрөө хариуцдаг. Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалт. УБ., 2009 он.

<sup>10</sup> **Шинжилгээг тал бүрээс нь бүрэн бодитой шинжлэх ухааны үндэслэлтэй хийх:** Шинжилгээ хийх эрх бүхий этгээд буюу тусгай мэдлэг эзэмшсэн шинжээч нь шинжилгээ хийхдээ аливаа нөхцөлд сэтгэл хөдлөл, субъектив санаа зорилго, төсөөлөлгүйгээр шинжлэх ухааны арга аргачлалыг ашиглан шинжилгээгээр тогтоогдож байгаа бодит зүй тогтол, мэдээллийг үнэлж, гагцхүү түүнд үндэслэн дүгнэлтэд хүрнэ. Шинжилгээг шинжлэх ухаанаар болон холбогдох эрх зүйн хэм хэмжээгээр батлагдаж, хүлээн зөвшөөрөгдсөн арга аргачлал, техник хэрэгсэл ашиглан хийж, шинжилгээний объектод байх шинж тэмдгүүдийг үндэслэн тухайн үйл баримттай холбоотой мэдээ мэдээллийг бий болгох ёстой. Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалт. УБ., 2009 он.

шүүхийн шинжилгээний байгууллагаас гадуур шинжилгээний байгууллагуудад ногдож байна.<sup>11</sup>

Монгол Улсын хувьд шүүхийн шинжилгээг дагнан хэрэгжүүлдэг төрийн байгууллага болох Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд 4 төрлийн 50 гаруй төрлийн шинжилгээг хийж байна. Бусад төрлийн шинжилгээг шинжилгээний байгууллагаас гадуур хийлгэж байна. Шүүхийн шинжилгээний байгууллагад 2014 онд нийт 65163 шинжилгээ хийсэн нь өмнөх оныхоос 12.38 хувиар өссөн дүнтэй байна. Нийт шинжилгээг чиглэлээр нь авч үзвэл 15.47 хувийг криминалистикийн шинжилгээ, 20.79 хувийг хими, биологи, ДНХ, бактериологи, физикийн шинжилгээ, 63.29 хувийг шүүх эмнэлгийн шинжилгээ тус тус эзэлж байна.

График.1 Шинжилгээний чиглэл



Хүснэгт 2. Шүүхийн шинжилгээний байгууллагад хийсэн шинжилгээний тоон үзүүлэлтийг сүүлийн 6 жилээр харьцуулсан нь

Шинжилгээний чиглэл, төрөл	2009	2010	2011	2012	2013	2014	
Криминалистикийн шинжилгээний чиглэлээр	Гарын мөр	3384	3684	3829	4392	5331	6743
	Мөр судлал	627	714	789	1037	1178	1296
	Бичиг баримт	1184	1408	1066	1555	1067	1295
	Дүр зураг	142	162	155	191	104	154
	Галтзэвсэг	424	161	268	255	271	216
	Тэсрэх төхөөрөмж	5	7	10	11	12	2
	Дүрс бичлэг	-	-	-	-	54	172
	Авто техник	-	-	-	-	51	166
	<b>Бүгд</b>	<b>5766</b>	<b>6136</b>	<b>6117</b>	<b>7441</b>	<b>8032</b>	<b>10085</b>
	Хими	3676	3740	5012	5194	4747	5529
Физик	206	149	194	245	156	169	
Биологи	7044	6274	6279	5509	5281	6107	

<sup>11</sup> Зинин А.М., Майлис Н.П. Судебная экспертиза. М.: 2001. С. 5.



<b>Хими, физик, биологи, ДНХ, бактериологийн шинжилгээний чиглэлээр</b>	ДНХ	133	205	304	419	546	869
	Бактериологи	446	534	611	662	899	877
	<b>Бүгд</b>	<b>11505</b>	<b>10869</b>	<b>12400</b>	<b>12029</b>	<b>11629</b>	<b>13551</b>
	Цогцост хийсэн шинжилгээ	2811	3479	3767	4267	3521	3742
	Хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ	20746	20835	23183	26249	29370	31535
	Хүний биед хийсэн бусад шинжилгээ /Бэлгийн холбогдолтой, нас тогтоох/	683	1067	1092	931	1099	1039
<b>Шүүх эмнэлгийн шинжилгээний чиглэлээр</b>	Хэргийн материалаар хийсэн шинжилгээ	953	944	1073	1165	1200	1360
	Шарилд хийсэн шинжилгээ /эксгумац/	29	21	26	25	25	39
	Гистологийн шинжилгээ	2274	2703	2800	3514	2888	3527
	<b>Бүгд</b>	<b>27496</b>	<b>29049</b>	<b>31941</b>	<b>36151</b>	<b>38103</b>	<b>41242</b>
<b>Шүүх эдийн засгийн шинжилгээний чиглэлээр</b>	Татвартай холбоотой	20	37	30	87	82	86
	Өмч хувьчлалтай холбоотой	6	6	-	-	-	-
	НД-ын шимтгэлтэй холбоотой	-	1	2	4	12	9
	Бэлэн мөнгөтэй холбоотой	39	36	48	73	87	40
	Эд хогшил, бараа	28	45	25	2	17	37
	Бусад зөрчил	28	18	36	19	18	24
	<b>Бүгд</b>	<b>121</b>	<b>143</b>	<b>141</b>	<b>278</b>	<b>216</b>	<b>285</b>
<b>НИЙТ</b>	<b>44888</b>	<b>46197</b>	<b>50599</b>	<b>55899</b>	<b>57980</b>	<b>65163</b>	

### 1.3. Шинжээчийн дүгнэлт, түүнийг үнэлэх асуудал

Шинжээчийн дүгнэлт гэдэг нь хэргийн талаарх нотлох баримтын нэг эх сурвалж бөгөөд шинжлэх ухаан, техник, урлаг, соёлын /тусгай мэдлэг шаардсан/ нарийн мэргэжилтэн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхээс тавьсан асуултад өгч буй хариулт болно.

Өөрөөр хэлбэл, шинжилгээний явц, үр дүнгийн талаар шинжээчээс бичгээр илэрхийлсэн илэрхийлэл юм.<sup>12</sup> Монгол Улсын Шүүхийн шинжилгээний тухай хуульд “шинжээчийн дүгнэлт” гэж шинжээч өөрийн тусгай мэдлэгийн хүрээнд хийсэн шинжилгээний явц, үр дүнг тусгасан нотлох баримтын эх сурвалж болох баримт бичгийг хэлнэ<sup>13</sup> гэж тодорхойлсон. Харин судлаач, дэд профессор Б.Лхагвасүрэн “шинжээчийн дүгнэлт гэдэг нь шинжээч шинжлэх ухаанч аргачлал, ашиглан шинжилгээний зүйлийг шинжилсэн үйл ажиллагааны явц, үр дүнг харуулсан нотолгооны эх сурвалж буюу байцаан шийтгэх ажиллагааны баримт бичиг мөн” гэж тодорхойлсон байна. Шинжээчийн дүгнэлт нь нотлох баримтын эх сурвалж болохын хувьд тодорхой бүтэцтэй байдаг. Дүгнэлт нь удиртгал, шинжилгээний хэсэг, дүгнэлтийн үндэслэл, тайлбарын хэсэг, дүгнэлтийн гэсэн бүрдэл хэсгүүдийг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 3. Шинжээчийн дүгнэлтийн бүтэц

Шинжээчийн дүгнэлтийн бүтэц	Тайлбар	
Удиртгал	<ul style="list-style-type: none"> <li>➤ Шинжээчид хууль сануулсан байдал, дүгнэлт гаргасан он, сар, өдөр, дүгнэлтийн дугаар, шинжилгээ хийж буй этгээдийн албан тушаал, боловсрол, мэргэжил, эрдмийн зэрэг, туршлага гэх мэт;</li> <li>➤ Мөн шинжилгээ хийлгэх эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл, тогтоол, захирамжийн огноо, дугаар;</li> <li>➤ Хэргийн товч утга;</li> <li>➤ Шинжилгээнд ирүүлсэн зүйлс /шинж чанар, тоо, ширхгийг бичнэ/;</li> <li>➤ Шинжээчээс асуусан асуулт зэргийг тусгана.</li> </ul>	
Шинжилгээний хэсэг	Үзлэгийн	Шинжилгээнд ирүүлсэн зүйлсийг тогтоолд дурдсантай төрөл, ширхэг, хэлбэр агуулгаараа тохирч байгааг тулган гэрэл зургаар бэхжүүлнэ. Шинжилгээний зүйлийг шинжилгээнд тэнцэх болон тэнцэхгүй талаар дурдана.
	Шинжилгээний	Шинжилгээний зүйлийг оношлогооны болон адилтгалын ямар аргыг ашиглан шинжилсэн шинжилгээний явц, илрүүлсэн онцлог тэмдэг боловсруулалт болно.
Дүгнэлтийн үндэслэл, тайлбарын хэсэг	<ul style="list-style-type: none"> <li>➤ Шинжилгээний зүйлсээс илрүүлсэн шинж тэмдгүүд нь оношлогооны ямар зүй тогтолтой, адилтгалын ямар ач холбогдолтой буюу шинжилгээний ач холбогдлыг дурдаж, дүгнэлтэд хүрсэн үндэслэл, шинжлэх ухааны тайлбарыг тодорхойлон бичнэ.</li> <li>➤ Мөн асуулт асуугаагүй боловч шинжилгээний явцад илэрсэн хэрэгт ач холбогдолтой мэдээллийг шинжээч өөрөө тогтоовол энэ хэсэгт дурдана.</li> </ul>	
Дүгнэлтийн хэсэг	Зөвхөн шинжээчээс асуусан асуултын дагуу шинжилгээний үр дүнд бий болсон хариултыг бичнэ.	

**Шинжээчийн дүгнэлтийг үнэлэх:** Аливаа хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны явцад гарч буй баримт бичгүүд нь үргэлж хууль зүйн үр дагавар бий болгож байдгийн нэгэн адил шинжээчийн дүгнэлт нь шууд болон шууд бусаар хууль зүйн үр дагавар бий болгож цагаатгах болон яллах талаар гарч буй шүүхийн шийдвэрийн үндэслэл болохын хувьд тодорхой шалгуурыг хангасан байх ёстой бөгөөд тэрхүү шалгуураар шинжээчийн дүгнэлтийг үнэлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ. Харамсалтай нь шинжлэн магадлахуйн онолын болоод практик төлөвшилт сул, хууль эрх зүй, шинжилгээ судалгааны орчин зөв бүрдээгүй, шинжилгээний батлагдаагүй, стандартчилагдаагүй арга, арга зүйн тогтолцоо, шинжилгээний лабораториудын бүс нутгийн болон олон улсын байгууллагаар итгэмжлэгдээгүй байдал, хууль сахиулагчид болон хуульчдын шүүх шинжилгээний онолын мэдлэггүй байдал, мэдүүлгийг чухалчилсан шинжлэх ухаанч бус сэтгэлгээ амь бөхтэй

<sup>12</sup> Т.Оюунчимэг, Ц.Ариунболд нар., “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь шинжилгээ” сургалтын гарын авлага., 2006 он. Хуудас 38 дахь тал

<sup>13</sup> Шүүхийн шинжилгээний тухай хууль., 6 дугаар зүйлийн 6.1.5., 2009 он.

оршиж байгаа зэргээс шинжээчийн дүгнэлтийг үнэлэхгүй байх, үнэлсэн ч дайвар хэлбэрээр бусад нотлох баримтаас шууд хамааралтайгаар үнэлэх, аль эсвэл хэт шинжээчийн дүгнэлтийг үнэлэх, шүтэх явдал хэвшмэл болжээ.

“Шинжээчийн дүгнэлтийг нотлох баримтын хувьд үнэлэхэд ач холбогдлоороо нэгдүгээрт үнэн зөв дүгнэлт гарсан эсэхийг тогтоох учиртай” гэж Ю.Г.Корухов бичжээ.<sup>14</sup> Шинжээчийн дүгнэлтийг хууль сахиулагчид болон хуульчид үнэлэхдээ шинжээчийн дүгнэлтийн хууль зүйн үндэслэл, шинжилгээний явцад дүгнэлт гаргахад баримталсан байдал, шинжилгээ хийсэн арга аргачлал, шинжилгээний явц, үр дүн, дүгнэлтийн бүтэц, хэлбэр, агуулгыг харгалзан үзэх ёстой. Үүнээс үүдэн шинжээчийн дүгнэлтийг үнэлэх эрх бүхий этгээдүүд нь шинжлэн магадлахуйн тодорхой мэдлэгтэй байх ёстой гэсэн ойлголт гарч ирж байна.

Шинжээчийн дүгнэлтийн үнэн зөв эсэхэд үнэлгээ өгөхөд бусад нотлох баримттай иж бүрнээр нь авч үздэг. Бүх нотлох баримтууд нь иж бүрэн, цогцоороо үнэлэгдэх ёстой. Гэхдээ шинжээчийн дүгнэлтийн бодит байдлын нэг хэмжүүр нь хэргийг мөрдөн шалгах явцад цугларсан бусад нотлох баримтуудтай тохирч байх ёстой гэсэн үг биш. Зөвхөн тухайн шинжээчийн дүгнэлт, шинжилгээ судалгаа явуулсан явц, үр дүн зэрэгт бүрэн дүүрэн үнэлгээ өгснөөр хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхэд тухайн дүгнэлтийг бодит болсон гэж үзэх эрх олгоно. Түүнээс биш бусад нотлох баримттай харьцуулж үзсэнээр бодит үнэлгээ өглөө гэж үзэж болохгүй юм. Энэ талаар Ю.Г.Корухов: “Шинжээчийн дүгнэлтэд үнэлгээ өгөх асуудалд түүнийг бусад нотлох баримттай харьцуулж үзэх ёстой гэсэн үзэл баримтлал нь шинжээчийн дүгнэлтийг бодитой дүгнэх чадваргүй байдал харагдаж байгаа юм” гэж хэлсэн байдаг. Шинжээчийн дүгнэлтэд үнэлгээ өгөхдөө хуулийн шаардлагыг баримтлах нь мөрдөн байцаагч, шүүхэд шинжээчийн гаргасан дүгнэлтийг бодитоор үнэлэх боломж олгодог.

Шинжээчийн дүгнэлтэд өгөх мөрдөн байцаагч болон шүүхийн үнэлгээний талаар бид ярьж ирсэн боловч магадлалгаа шинжилгээний явц, үр дүнд шинжээч өөрөө ч үнэлгээ өгдөг. Энэ нь шинжээчийн олон талт үйл ажиллагааны үнэлэлт дүгнэлтийн нэг хэсэг болно. Шинжээчийн үйл ажиллагаанд өгөх үнэлэлт дүгнэлтийн хэсгийг чухалчлан Л.Е.Ароцкер үзэхдээ үнэлгээний үр дүн хамаарах бүтцийн хэсэгт магадлан шинжилгээний танин мэдэхүйн объект болон субъектийг тодотгох шаардлагатай гэсэн байдаг. Түүний үзэж байгаагаар нэг талаас объектыг гүн гүнзгий, олон талаас нь магадлан шинжлэх явдал, нөгөө талаас объект болон субъектийн зүй тогтлын тухай мэдлэг зэрэг нь шинжээчийн үнэлэлт дүгнэлтийн цар хүрээг тодорхойлох боломж олгодог.<sup>15</sup> Өөрөөр хэлбэл, тодорхой магадлан шинжилгээ хийхэд өгөгдсөн объектыг шинжлэн судлахад болон хийгдсэн шинжилгээний үр дүнд үнэлгээ өгөх үед тухайн шинжилгээний арга зүйгээр зөвшөөрөгдсөн арга барил, техник хэрэгслийг эзэмшсэн байгаад зогсохгүй мөн тухайн объектын үндсэн зүй тогтлуудыг мэддэг байх ёстой.

Хэдийгээр шинжээчийн дүгнэлтийн талаар баримталбал зохих шалгуурыг хууль тогтоомжид нарийвчлан тусгаж өгөөгүй хэдий ч шинжлэн магадлахуйн шинжлэх ухааны онолын үүднээс дараах байдлаар авч үзэж байна. Шинжилгээний эцсийн үр дүн болох шинжээчийн дүгнэлтийг үнэлэхдээ дараах шалгуурыг харгалзан үзнэ. Үүнд:

- Хууль зүйн шалгуур;
- Шинжлэх ухааны шалгуур;
- Техник шалгуурууд болно.

<sup>14</sup> Д.Сүхбат., “Шинжээчийн дүгнэлтийн үнэлэмж түүнийг сайжруулах нь”, 2013он. Магистрын ажил., хуудас 87 дахь тал.

<sup>15</sup> Д.Сүхбат., “Шинжээчийн дүгнэлтийн үнэлэмж, түүнийг сайжруулах нь”, Магистрын ажил., 2013 он., 67 дахь тал.

**Хууль зүйн шалгуур нь:**

Шүүхэд аливаа, хэрэг маргааныг хянан шийдвэрлэхэд шинжээчийг оролцуулах ажиллагаа нь хуульд заасан нарийн процессын дагуу явагддаг. Шинжээчийн дүгнэлтийг үнэлэхдээ юуны өмнө холбогдох хууль эрх зүйн актаар тогтоосон журмыг чанд мөрдсөн эсэхэд анхаарах нь чухал. Тухайлбал, шинжээчид шинжилгээ хийхээс нь өмнө Монгол Улсын ЭБШ хуулийн 46 дугаар зүйл, Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 13, 14 дүгээр зүйлд заасан эрх, үүргийг нь тайлбарлан өгч, Монгол Улсын Эрүүгийн хуулийн 254, 255 дугаар зүйлд заасан хариуцлагыг биечлэн болон бичгээр сануулж, шинжилгээ хийлгэх тогтоолд шинжээчээр гарын үсэг зуруулсан байх ёстой. Хуульд заасан бусад үндэслэл, журмыг баримтлах, түүнчлэн тогтоол, захирамжийг баталгаажуулсан байгууллагын тамга, тэмдгийн дардас, шинжилгээ хийлгэхээр даалгасан албан тушаалтны гарын үсэг нь эх хувь байх ёстой. Мөн эрүү, иргэн, захиргааны хэргийн дугаарыг заавал бичсэн байна.

**Шинжлэх ухааны шалгуур:**

- Шинжээчээс асуусан асуултад орчин үеийн шинжлэх ухааны арга, хэрэгсэл хариулт өгөх боломжтой байх ёстой бөгөөд ингээгүй тохиолдолд шинжээч дүгнэлт гаргаж болохгүй юм.
- Шинжилгээнд хүргүүлсэн зүйлс шинжээчээс асуусан асуултад хариулт өгөхөд тоо болон чанарын хувьд хангалттай, боломжтой байна.
- Шинжээч өөрийн эзэмшсэн тусгай мэдлэгийн хүрээнд шинжилгээ хийх бөгөөд өөрийн эзэмшсэн мэдлэг, мэргэжлээс өөр салбар, чиглэлээр дүгнэлт гаргахгүй. Зөвхөн өөрийн мэдлэгийн хүрээнд дүгнэлт гаргана.
- Шинжилгээний аргачлал нь шинжлэх ухааны үндэслэлтэй, найдвартай байхын зэрэгцээ албан ёсоор баталгаажсан, хүлээн зөвшөөрөгдсөн байна
- Шинжилгээ хийх тогтсон үе шатыг баримталсан байх ёстой бөгөөд холбогдох үе шатаар хийгдээгүй шинжилгээний эцсийн үр дүн өөрчлөгдөх, буруу гарах магадлалтай юм.
- Шинжилгээ хийх аргыг зөв хослуулсан байх, ямар нэгэн эрсдэлгүй байх ёстой.
- Шинжилгээнд шаардлагатай багаж, хэрэгслийг ашигласан байна. Ямар ч багаж хэрэгсэл ашиглаагүй бол үр дүнд хүрч дүгнэлт гарган гэдэг утгагүй юм.
- Оношилгооны болон адилтгалын ач холбогдол бүхий шинж тэмдгүүдийн нийлбэр цогц болон шинжилгээгээр тогтоогдсон шинж тэмдэг, өөрчлөлт, шалтгааныг олж тогтоон тэдгээрт үндэслэн дүгнэлтэд хүрсэн байна. Шинжилгээ болгон хэдий өөр өөр арга, аргачлалтай боловч шинжээчийн дүгнэлтийн хэлбэр, бүтцийг нэг загварт оруулан ашиглах нь хууль зүйн болон практик ач холбогдолтой юм.

**Техникийн шалгуур:**

- Монгол хэл, шинжилгээ судлалын тогтсон нэршлийг хэрэглэсэн байх;
- Утга найруулга зүй, зөв бичих дүрмийн алдаагүй байх;
- Дүгнэлтийн хуудас хуудас болон гэрэл зураг бүрд шинжээч гарын үсэг зурж, шинжээчийн хувийн тэмдгээр болон албаны баталгаажуулалтын тэмдгээр баталгаажуулсан байх;
- Гэрэл зургийн үзүүлэлтэд тайлбар, хаяг, тэмдэглэгээ хийсэн байх зэрэг болно.<sup>16</sup>

<sup>16</sup> Б.Лхагвасүрэн., “Криминалистикийн шинжилгээ судлал”., 2010 он. 26-27 дахь тал.

#### 1.4. Шинжээчийн дүгнэлт гаргаж буй этгээдүүд


Монгол Улсын Их Хурлын 1998 оны 18 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”-ийн 44 дүгээр зүйлд “хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүх, прокурор болон хууль сахиулах бусад байгууллагатай ажлын нягт уялдаа холбоотой криминалистик, шүүх-эмнэлэг, санхүү нягтлан бодох бүртгэл зэрэг шинжилгээний байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг хянан үзэж, нэгдсэн зохион байгуулалтад оруулан материаллаг баазыг нь бэхжүүлэх арга хэмжээ авна” гэсэн заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 63 дугаар тогтоолоор Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнг /тухайн үед “Шүүхийн шинжилгээний үндэсний төв” нэртэй байв/ байгуулжээ. Тус хүрээлэнд Эрүүл мэндийн яамны харьяа Шүүх эмнэлгийн магадлах төв, Сангийн сайдын дэргэдэх Шүүх нягтлан бодох бүртгэлийн магадлах товчоо, Цагдаагийн ерөнхий газрын Шинжилгээний хүрээлэнг нэгтгэсэн байна. Шүүхийн шинжилгээний байгууллагын бүтэц, орон тоо нь 2005, 2009, 2011, 2013, 2015<sup>17</sup> онуудад шинэчлэгдсэн ирсэн. Хууль зүйн сайдын 2015 оны А/23 тоот тушаалаар Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн бүтэц, орон тооны дээд хязгаарыг шинэчлэн дараах бүтэцтэй баталсан байна. Үүнд:

- Захиргаа удирдлагын хэлтэс;
- Хяналт шинжилгээ, үнэлгээний дотоод аудитын тасаг;
- Санхүү, төлөвлөлтийн тасаг;
- Стратеги, бодлого төлөвлөлтийн хэлтэс;
- Шинжилгээний бүртгэл, мэдээллийн хэлтэс;
- Хангамж, техникийн үйлчилгээний хэлтэс;
- Криминалистикийн шинжилгээний хэлтэс;
- Шүүх эмнэлгийн шинжилгээний хэлтэс;
- Тусгай шинжилгээний хэлтэс;
- Эдийн засгийн шинжилгээний хэлтэс;
- Аймаг, нийслэлийн шүүхийн шинжилгээний алба, тасаг, хэсэг гэсэн бүтэцтэйгээр зохион байгуулж, нэгж тус бүрийн гүйцэтгэх үүргийг тодорхойлж өгсөн болно.

<sup>17</sup> Хууль зүйн сайдын 2015 оны А/23 тоот тушаал



Схем зураг 4. Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн бүтэц



**Шүүхийн шинжилгээний байгууллагын чиг үүрэг:** Шүүхийн шинжилгээний байгууллага нь эрүү, иргэн, захиргааны болон бусад хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нотлох баримтыг илрүүлж бэхжүүлж авах, ул мөр, эд мөрийн баримтад үзлэг, шинжилгээ хийж, шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий төрийн байгууллага юм.<sup>18</sup> Шүүхийн шинжилгээний тухай хуульд зааснаар шүүхийн шинжилгээг шинжилгээний байгууллагаар хийлгэхээс гадна шинжилгээний байгууллагаас гадуур хийлгэж болохоор заасан. Шинжилгээг шүүхийн шинжилгээний байгууллагаас гадуур хийлгэх бол шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд шинжилгээ хийлгэх тухай тогтоол, захирамж, хүсэлт гаргаж, шинжилгээ хийхээр томилогдож байгаа шүүхийн шинжилгээний байгууллагад ажилладаггүй шинжээчийг дуудан ирүүлж, түүний биеийн байцаалт, мэргэжил, чадвартай танилцан, сэжигтэн, яллагдагч, хохирогчтой ямар харилцаатай болохыг тогтоохоос гадна шинжээчээс татгалзан гарах үндэслэл байгаа эсэхийг шалгана.<sup>19</sup> Сүүлийн 3 жилийн байдлаар шүүхэд шинжээчийн дүгнэлт гаргасан нэр бүхий

<sup>18</sup> Энэ байгууллагын зорилго нь шинжлэх ухааны тодорхой салбарын шинжилгээ судалгааны онол, арга зүйд түшиглэн хэргийн газрын үзлэгийг мэргэжлийн өндөр төвшинд зохион байгуулан хийж, ул мөр бэхжүүлэх, нотлох баримт цуглуулах, хэргийн нотлох баримтад өндөр технологи, орчин үеийн техник хэрэгсэл ашиглан эрх бүхий байгууллагын тогтоол, захирамж, хүсэлтээр шинжилгээ хийж, шинжлэх ухааны үндэслэлтэй, үнэн зөв дүгнэлт магадалгаа гаргах, алба хаагчдын тогтвортой ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

<sup>19</sup> Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалт, УБ 2009 он.

байгууллагуудаас судалгаа авч ямар төрлийн шинжилгээ гаргасан, нийт хэдэн удаа шинжээчээр томилогдон ажилласан талаар судалсныг дараах хүснэгтээр харуулав.

**Хүснэгт 5. Шинжилгээний байгууллагаас гадуур хийгдсэн шинжилгээ**

№	Он	Тайлбар
<b>Газрын харилцаа, Геодези, Зураг зүйн газар нь</b>		
1.	2012	2012 онд нийт 60 хэрэг маргаанд оролцохдоо 19 газрын маргаанд лавлагаа, нотлох баримт, 41 газрын маргаанд шинжээчийн дүгнэлт гаргасан.
2.	2013	2013 онд нийт 126 хэрэг, маргаанд оролцохдоо 65 газрын маргаанд лавлагаа, нотлох баримт, 61 газрын маргаанд шинжээчийн дүгнэлт гарган оролцсон.
3.	2014	2014 онд онд нийт 136 хэрэг маргаанд оролцохдоо 73 газрын маргаанд лавлагаа, нотлох баримт, 63 газрын маргаанд шинжээчийн дүгнэлт гарган оролцсон байна. Шинжээчээр оролцохдоо Иргэний хэргийн шүүх, Захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн захирамжаар, Мөн авилгатай тэмцэх газар, Цагдаагийн газрын мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч нарын тогтоолоор шинжээчээр томилогдон ажилласан байна.
<b>Мэргэжлийн хяналтын Ерөнхий газар</b>		
2012 онд нийт 11, 2013 онд нийт 16 хэрэг маргаанд шинжээчээр оролцсон. 2014 онд 35 хэрэг, маргаанд шинжээчээр оролцохдоо шинжээчийн бүрэлдэхүүнд орж ажиллан дүгнэлт гаргасан байна.		
<b>Монгол банк нь:</b>		
4.	2013	2013 онд нийт 14 хэрэг, маргаанд, 26 шинжээч оролцсон.
5.	2014	2014 онд нийт 11 хэрэг маргаанд, 21 шинжээч оролцсон.
6.	2015	2015 онд нийт эхний хагас жилийн байдлаар 9 хэрэг маргаанд, 16 шинжээч оролцсон байна. Шинжээчээр оролцохдоо Иргэний хэргийн шүүх, Захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн захирамж, мөн Авилгатай тэмцэх газар, Цагдаагийн газрын мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч нарын тогтоолоор шинжээчээр томилогдон ажилласан байна.
<b>Шинжилгээний төрлийн хувьд:</b>		
<ul style="list-style-type: none"> <li>- Банкны зээлийн болон хадгаламжийн үйл ажиллагаатай холбоотойгоор зээл, хадгаламжийн хүү бодолт, ханшийн зөрөөний тооцооллыг шалгах;</li> <li>- Банкны нягтлан бодох бүртгэл, тайлан тэнцэл, төлбөр тооцоо, аж ахуй нэгж байгууллагын харилцах данс, түүний гүйлгээ, арилжааны хэлцэлтэй холбоотой хэргүүд;</li> <li>- Банкны төлбөрийн карт (гадаад, дотоод)- тай холбогдуулан хуурамч төлбөрийн карт ашигласан, залилсан дотоод, гадаад иргэдтэй холбоотой хэргүүд;</li> <li>- Банкны аккредитив, баталгаа, батлан даалттай холбоотой хэргүүд;</li> <li>- Банкны мэдээллийн технологи буюу банкны нягтлан бодох бүртгэлийн програм хангамж, мэдээллийн баазтай холбоотой ашиглалтын хэрэг;</li> <li>- Банкны хувь нийлүүлэгч, банкны гүйцэтгэх удирдлага, ажилтнууд банкны тухай хууль тогтоомж зөрчсөн эсэхтэй холбоотой хэргүүдэд шинжээчээр томилогдож ажилласан байна.</li> </ul>		

**Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар:** 2013 онд 30 гаруй 2014 онд 70 хэрэг, маргаанд харин 2015 оны эхний хагас жилийн байдлаар 50 хэрэг, маргаанд шинжээчээр оролцсон байна. Шинжээчээр оролцохдоо хүүхэд, гэр бүлийн хөгжлийн төв нь Иргэний хэргийн шүүхийн шүүгчийн захирамжаар шинжээчээр томилогдон ажилласан байна. Шинжилгээний төрлийн хувьд эцэг тогтоох, асран хамгаалагч тогтоох зэрэгт дүгнэлт гарган оролцсон.

**Барилгын хөгжлийн төв нь:** Барилгын хөгжлийн төв нь 2012 оны 10 сараас хойш (Эрүүгийн хуулийн 138 дугаар зүйл) Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн журам зөрчих 2 хэрэгт шинжээчийн дүгнэлт гарган оролцсон. 2013 оны хувьд нийт 24 хэрэг, маргаанд шинжээчээр оролцохдоо барилгын гүйцэтгэлийн төсвийг хянах маргаанд 20, барилга хоорондын нарны гэрэлтүүлэг дүрэмд нийцэж байгаа эсэх маргаанд 4 удаа шинжээчээр

томилогдсон байна. 2014 онд нийт 28 хэрэг, маргаанд оролцохдоо барилгын гүйцэтгэлийн төсвийг хянах маргаанд 16, барилга хоорондын нарны гэрэлтүүлэг дүрэмд нийцэж байгаа эсэх 6 маргаанд, мөн Эрүүгийн хуулийн 138.2 зүйлд холбогдох Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн журам зөрчих хэрэгт шинжээчээр дүгнэлт гарган оролцсон байна. Шинжээчээр оролцохдоо Иргэний хэргийн шүүхийн шүүгч, Захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн захирамж болон Цагдаагийн газрын мөрдөн байцаагч нарын тогтоолоор шинжээчээр томилогдон ажилласан байна.

**Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт:** 2014 онд Улсын мөрдөн байцаах газрын Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсээс ирүүлсэн эдийн засгийн шинжилгээ хийх тогтоолын дагуу татвар төлөхөөс зайлсхийсэн, мөнгө угаасан эрүүгийн хэрэгт бүрэлдэхүүнтэй шинжээчийн багт орж ажиллан 166.9 тэрбум төгрөгийн зөрчилд 35.2 тэрбум төгрөгийн нөхөн татвар ногдуулсан байна.

Дээрх байгууллагуудаас ирүүлсэн саналыг нэгтгэн үзвэл өөрсдийн ажлын байрны тодорхойлолтод “шинжээч”-ээр ажиллах чиг үүрэг тусгагдаагүйгээс гадна тус байгууллагуудын төсөвт хөрөнгөнд тусгагдаагүй, хууль тогтоомжоор хүлээсэн үүрэгт ажлаа явуулах хөрөнгө бага байдаг тул шинжээчээр ажиллахад зарцуулах хөрөнгө мөнгө гаргах боломжгүй байдаг байна. Тухайлбал, гэрлэлт цуцалт дахь хүүхдийн асран хамгаалалтын маргаанд шинжээчээр ажиллахад шүүгчийн захирамжид байгууллагын хаяг буруу бичигдэж, шат шатандаа дамжин явсаар захирамжид заасан хугацаа дууссан хойно зохих шатны байгууллагад ирэх тохиолдол байна.

Шинжээчээр ажиллахад мэдлэг ур чадвар их шаарддаг тул ажиллагаа ихтэй, цаг хугацаа их шаардсан ажил байдаг тул шүүгчийн захирамж, мөрдөн байцаагчийн тогтоолд заасан хугацаанд дүгнэлт гаргаж өгөх боломж бага байдаг. Мөн ажилласан багийн хөлсийг нэхэмжлэгч, хариуцагч талуудаас гаргуулах шаардлага гардаг. Дүгнэлт гарсны дараа зардал гаргуулна гэдэг боловч зардлыг олгох тал дээр хүндрэл үүсдэг. Мөн хэргийн оролцогч талуудаас шинжээч рүү дайрч доромжлох, заналхийлэх явдал гардаг байна. Иймд шүүхийн шинжилгээг шинжилгээний байгууллагаас гадуур хийлгэх хууль эрх зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ. ШҮҮХЭД ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ ГАРГАЖ БУЙ ПРАКТИКТ ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

### 2.1. Эрүүгийн хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаан дахь шинжээчийн дүгнэлт

Эрүүгийн хэрэгт шинжлэх ухаан, техник, нягтлан бодох бүртгэл, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа зэрэг тусгай мэдлэгийн үнэлэлт зайлшгүй шаардлагатай асуудлаар шинжээч томилж, шинжилгээ хийлгэн дүгнэлт гаргуулдаг. Шинжээч томилж, шинжээчийн дүгнэлт гаргуулах журмыг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 85, 155-165, тэдний шүүх хуралдаанд оролцуулж мэдүүлгийг нь сонсох, дүгнэлтийг нь тайлбарлуулах журмыг мөн хуулийн 271-273 дугаар зүйлүүдээр зохицуулсан байдаг. Мөн шүүх шинжилгээний хуулиар шүүхийн шинжилгээ хийх журмыг нарийвчлан зохицуулдаг байна.

Шүүхээр хянан шийдвэрлэгдэж буй эрүүгийн хэрэгт Шинжээчийн ямар төрлийн дүгнэлтийг гаргуулдаг, шинжээчийн дүгнэлтийг шүүхээс томилж гаргуулж буй эсэх, шинжээчийн дүгнэлт шүүхийн шийдвэрийн үндэслэл хэрхэн болж байгаа, цаашид шинжээчийн дүгнэлттэй холбоотой ямар зүйлүүдийг анхаарвал зохихыг тодорхойлох зорилгоор шүүхүүдээр 2013-2015 онд хянан шийдвэрлэгдсэн нийслэлийн 115 эрүүгийн хэрэгт, Дархан-Уул аймгийн 8 эрүүгийн хэрэгт, Орхон аймгийн 14 эрүүгийн хэрэгт, Сэлэнгэ аймгийн 10 эрүүгийн хэрэгт, түүн дотроо Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн ... зүйлүүдэд заасан хэрэгт гаргасан шинжээчийн дүгнэлтүүдийг судалж энэхүү судалгааг хийлээ. Судалгаанд хамрагдсан шинжээчийн дүгнэлт бүхий хэргүүдийг сонгон авахдаа тухайн хэргүүдийг хянан шийдвэрлэсэн шүүхүүдийн шүүгч нартай ярилцлага хийж сонгон авсан бөгөөд энэ нь практикийг оновчтой судлах, шинжээчийн дүгнэлт гаргахад анхаарах асуудлуудыг зөв судлахад чухал ач холбогдолтой гэж үзсэн. Шүүх таслах ажлын статистик мэдээг үндэслэн Улаанбаатарт гарч байгаа хэргүүдийн төрөл олон байсан учир хэргийн тоог нийслэлээс их сонгон авч судлав.

График.2.2.1






График.2.2.2



2014 онд Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхээр 1129 хэргийг хянан шийдвэрлэснээс шинжээчийн дүгнэлттэй холбоотойгоор 11 хэргийн шийтгэх тогтоол хэрэгсэхгүй болжээ.

График.2.2.3



2015 оны эхний хагас жилд Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхээр 501 хэргийг хянан шийдвэрлэснээс шинжээчийн дүгнэлттэй холбоотойгоор 4 хэргийн шийтгэх тогтоолыг хэрэгсэхгүй болгожээ. Үүнд:



График.2.2.4



Шинжээчийн дүгнэлт нь тухайн хэргийн гэмт хэргийн бүрэлдэхүүн, хэргийн зүйлчлэлд нөлөөлөх, шүүгдэгчийн гэм бурууг тогтоох, хохирогчид учирсан хохирлын хэр хэмжээг шийдвэрлэх гол үндсэн нотлох баримт болдог тул Шинжээчийн дүгнэлтийг эргэлзээгүй, зөв гаргах нь онцгой ач холбогдолтой байдаг байна. Шинжээчид эрх бүхий этгээдээс тавьж буй асуулт оновчтой биш, тодорхой биш тавигдсанаас, мөн хэргийн оролцогчдын шинжээчийн дүгнэлт гаргуулах ажиллагаанд оролцох хуулиар олгогдсон эрхийг бүрэн хангаагүй зэргээс шалтгаалан Шинжээчийн дүгнэлтийг давтан гаргуулах тохиолдол цөөнгүй байгаа тул шинжээчид тавигдах асуултад анхааралтай хандах шаардлагатай.

Зарим тохиолдолд, хэрэгт гаргасан шинжээчийн дүгнэлтүүд хоорондоо зөрүүтэй байгаа нь шинжээчийн дүгнэлтийг дахин дахин давтан гаргуулахад хүргэдэг байна. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 163 дугаар 163.3 дахь хэсэгт заасан “Шинжилгээ хийж байх үед шинжээч уг хэрэгт чухал ач холбогдол бүхий бусад зүйлийг олж тогтоосон бол энэ талаар асуулт тавигдаагүй ч байсан өөрийнхөө дүгнэлтэд заах үүрэгтэй” гэсэн заалтыг шинжээч заавал биелүүлэх шаардлагатай байна. Энэ нь шинжээчид үүрэг болгосон заалт байх ба энэ үүргийг шинжээчид биелүүлж байвал шинжээчээр нэмэлт дүгнэлт гаргуулах, давтан дүгнэлт гаргуулах үйл ажиллагаа багасахаар байна.

График.2.2.5



**Зөвлөмж:** - Шинжээчийн дүгнэлтийг давтан, олон дахин гаргуулах нь хэрэг шийдвэрлэгдэх хугацаанд нөлөөлөхөөс гадна, цаана нь хохирсон хүний эрх ашгийг хамгаалах төрийн чиг үүрэг төдий хугацаагаар удааширч байгаа гэдгийг анхаарах;  
-Шинжээчид тавьж буй асуулт оновчтой, тодорхой байх;

-Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 157 дугаар зүйлийн 157.1 дэх хэсэгт заасан “Шинжилгээ хийлгэх үед сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, өмгөөлөгч, хохирогч дор дурдсан эрх эдэлнэ:

157.1.1. шинжээчийг татгалзан гаргах хүсэлт гаргах;

157.1.2. шинжээчид нэмэлт асуулт тавих;

157.1.3. шинжээчид нэмэлт баримт бичиг өгөх, тэр талаар тайлбар гаргах;

157.1.4.хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорын зөвшөөрөлтэйгөөр шинжилгээ хийхэд байлцах;

157.1.5. шинжээчийн дүгнэлттэй танилцах” гэсэн эрхүүдийг нь бүрэн эдлүүлэх;

- Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 163 дугаар 163.3 дахь хэсэгт заасан “Шинжилгээ хийж байх үед шинжээч уг хэрэгт чухал ач холбогдол бүхий бусад зүйлийг олж тогтоосон бол энэ талаар асуулт тавигдаагүй ч байсан өөрийнхөө дүгнэлтэд заах үүрэгтэй” гэсэн заалтыг шинжээчид эрх, үүргийг нь танилцуулахдаа давхар танилцуулдаг болох;

- Шүүх хуралдаанд оролцож буй шинжээчид бүрэн дүүрэн хариулах боломжтой хийгээд хамгийн оновчтой, ач холбогдолтой асуулт тавьж, түүндээ хариулт авах.

Шинжээчийн дүгнэлт гаргуулдаггүй ч Шинжээчийн дүгнэлт зайлшгүй гаргуулах шаардлагатай “Эд хөрөнгийн үнэлгээг гаргуулах” асуудал өнөөдөр хүртэл орхигдон шийдвэрлэгдээгүй нь судалгаа хийх явцад ажиглагдлаа. Зөвхөн учирсан хохирлын хэмжээгээр гэмт хэргийн бүрэлдэхүүн нь хангагддаг 58 гэмт хэргийг, учруулсан хохирлын хэмжээнээс нь гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүн болдог 64 гэмт хэргийг Монгол Улсын Эрүүгийн хуулиар бэхжүүлжээ. Гэмт хэргийн бүрэлдэхүүн хүндэрснээс гэмт хэргийн ангилал хүндрэхээс гадна ялтанд оногдуулах ялын төрөл, хэмжээ нь хүндэрдэг. Жишээлбэл, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлд “Бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх” гэмт хэргийг заажээ. Уг зүйлийн 150.1 нэг дэх хэсэгт заасан “Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн өмчийг итгэмжлэгдэн хариуцсан этгээд завшсан буюу үрэгдүүлсний улмаас бага бус хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.” гэсэн гэмт хэрэгт нь гэмт хэргийн ангиллын хувьд хөнгөн гэмт хэрэг, хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нь 6 сар, ялын төрөл нь хөнгөн байсан бол мөн зүйлийн 150.2 дахь хэсэгт “Энэ хэргийг давтан буюу бүлэглэж үйлдсэн, энэ хэргийн улмаас бусдад үлэмж хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг таван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэж хохирлын хэмжээ “үлэмж” болсноор гэмт хэргийн ангилал хүндэвтэр болж, хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нь 5 жил болж, ялын төрөл нь, хэмжээ нь хүндэрч, мөн зүйлийн 150.3 дахь хэсэгт “Энэ хэргийн улмаас бусдад их буюу онц их хэмжээний хохирол учирсан бол эд хөрөнгийг хурааж, таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэж гэмт хэргийн ангилал хүнд болж, хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нь 15 жил болж, ялын хэмжээ илт хүндэрсэн байна.

Гэмт хэргийн бүрэлдэхүүнд хохирлын хэмжээ шаарддаг, хохирлын хэмжээгээр хүндэрдэг зарим гэмт хэргийн болон ял шийтгүүлэгчдийн тоо /улсын хэмжээгээр/:

Д/д	Хэргийн төрөл	Хэргийн тоо		Ял шийтгүүлэгчдийн тоо	
		2014 он	2015 он	2014 он	2015 он
1.	Бусдын эд хөрөнгийг хулгайлах	203	199	209	218
2.	Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх	164	198	318	369
3.	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	901	803	915	806
4.	Эд зүйлийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх	58	49	70	74

Энэхүү гэмт хэргүүдийн зүйлчлэлийн гол шалгуур болсон “Хохирлын хэмжээ”-г тогтоож буй эд зүйлийн үнэлгээг хэрэг гарсан газрын үнэлгээний комисс гэх 3-5 хүний бүрэлдэхүүнтэй, үнэлгээ хийх эрхгүй, санхүү- нягтлан бодох, худалдааны, зах зээлийн эдийн засгийн мэргэжилгүй, тухайн нутаг дэвсгэрийн Засаг даргын захирамжаар томилогдсон этгээдүүд гаргаж ирсэн практиктэй байна. Гэтэл иргэн болон захиргааны шүүхээр хянан шийдвэрлэгдэж буй эд хөрөнгийн үнийн дүн бүхий маргаантай хэргүүдэд эд хөрөнгийн үнэлгээг үнэлгээний эрхтэй байгууллагуудаар үнэлгээг гаргуулж хэргийг нь хянан шийдвэрлэж байна.

**Зөвлөмж, санал:** Материаллаг бүрэлдэхүүнтэй буюу хохирлын хэмжээгээр хэргийн зүйлчлэл хүндэрдэг, гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж нь хангагддаг гэмт хэргүүдийн хохирол болох эд хөрөнгийн үнэлгээг Шинжээчийн дүгнэлтээр гаргуулж байх шаардлага нэн тулгамдаж байна. Үүнийг Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Эдийн засгийн шинжилгээний хэлтсээр гаргуулах, эсхүл Хөрөнгийн үнэлгээний эрх бүхий байгууллагаар гаргуулах зохицуулалтыг Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Шүүх шинжилгээний тухай хуульд заах.


## 2.2. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь шинжээчийн оролцоо

Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхээс 2013-2015 оны эхний хагас жилийн байдлаар шийдвэрлэгдэж, хуулийн хүчин төгөлдөр болсон хэргийн хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шинжээч томилогдсон хэргийг түүвэрлэн авч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь шинжээчийн оролцооны байдалд судалгаа хийлээ. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шинжээчийг томилох асуудал Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэгт “Захиргааны хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулах, үнэлэх үүргийг захиргааны хэргийн шүүх гүйцэтгэнэ” гэж заасны дагуу уг хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэгт “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нотлох баримтыг ойлгох, гаргаж өгөх, цуглуулах, үнэлэхдээ энэ хуульд өөрөөр заагаагүй бол Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 37, 40-45, 47-49, 51 дүгээр зүйлд заасан журмыг баримтална”, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсэгт “Хэргийн нотлох баримт нь зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчийн тайлбар, гэрчийн мэдүүлэг, бичмэл ба эд мөрийн баримт, эсхүл баримт бичиг, шинжээчийн дүгнэлт зэрэг нотолгооны хэрэгслээр тогтоогдоно”, мөн хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 “Хэрэг хянан шийдвэрлэхэд шинжлэх ухаан, тооцоо, тоо бүртгэл, урлаг, утга зохиол, техникийн зэрэг тусгай мэдлэг шаардагдах

асуудлыг тодруулахын тулд хэргийн оролцогчийн хүсэлтээр шүүхийн санаачилгаар шүүгч захирамж гарган шинжээчийг томилно”, мөн хуулийн 47.2-д “Шинжээч шинжилгээ хийж дүгнэлт гаргахдаа Шүүхийн шинжилгээний тухай хуульд заасан журмыг баримтална” гэж заасан журмын дагуу захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шинжээч томилох ажиллагаа явагдаж байна.

Нийслэлийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс 2013 онд 573 хэрэг, 2014 онд 634 хэрэг, 2015 оны эхний хагас жилийн байдлаар 404 хэрэг шийдвэрлэгдсэнээс 2013 оны 3 хэрэгт, 2014 оны 9 хэрэгт, 2015 оны эхний хагас жилд 1 хэрэгт /хуулийн хүчин төгөлдөр болсон/ шинжээч томилжээ.


График.2.1.1



Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхээс 2013-2015 оны эхний хагас жилд шинжээч томилогдон шийдвэрлэгдсэн хэргийг маргааны төрлөөр нь авч үзвэл:


- 1.Газрын маргаан буюу барилга байгууламж ашиглалтад оруулсан акттай холбоотой маргаан-9
- 2.Татварын маргаан буюу улсын байцаагчийн акттай холбоотой маргаан-2
- 3.Тендерийн маргаан -1
- 4.Гаалийн татвар буюу бүрдүүлэлтийн дараах хяналт шалгалттай холбоотой маргаан-1

График.2.1.2



Мөн Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 “Захиргааны хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулах, үнэлэх үүргийг захиргааны хэргийн шүүх гүйцэтгэнэ” гэсний дагуу шүүхийн санаачлагаар 8 хэрэгт, хэргийн оролцогчдын хүсэлт буюу нэхэмжлэгч, хариуцагч гуравдагч этгээд, тэдгээрийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтээр 5 хэрэгт шинжээчийг томилон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулжээ.

График.2.1.3



2013 оноос 2015 онд шийдвэрлэгдсэн 13 хэрэгт шинжээч томилогдсон дор дурдсан маргаанд дараах төрлийн шинжилгээ хийгджээ. Үүнд:


1. Газрын маргаан буюу барилга байгууламж ашиглалтад оруулсан акттай холбоотой маргаан /баримт бичгийн хэв шалгах, байгаль орчинд нөлөөлөх байдал, барилгын норм дүрэм, стандартыг зөрчсөн эсэх, газрын давхцал, кадастрын мэдээллийн санд орсон өөрчлөлтийн үнэн зөв эсэх/

2. Татварын маргаан буюу улсын байцаагчийн акттай холбоотой маргаан /санхүүгийн тайланд шинжилгээ хийх/

3. Тендерийн маргаан /тендер шалгаруулалт холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу явагдсан эсэх, стандарт шаардлага/

4. Гаалийн татвар буюу бүрдүүлэлтийн дараах хяналт шалгалттай холбоотой /санхүүгийн анхан шатны бүртгэлд шинжилгээ, гаалийн мэдүүлгийн үнэн зөв/


График.2.1.4





2013 оноос 2015 оны эхний хагас жилд шийдвэрлэгдсэн 13 хэрэгт дараах байгууллагууд шинжээчээр томилогдон дүгнэлт гаргажээ:


График.2.1.5



2013 оноос 2015 оны эхний хагас жилд тус шүүхийн шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолоор шинжээч томилон шийдвэрлэгдсэн 13 хэргийн хувьд шинжээчийн дүгнэлт гарсан хугацаа харилцан адилгүй байна. Үүнд:


- 18 хувь нь 14-1 сарын хугацаанд
- 53 хувь нь 1-3 сарын хугацаанд
- 12 хувь нь 3-6 сарын хугацаанд
- 18 хувь нь 6-9 сарын хугацаанд тус тус шинжээчийн дүгнэлтийг гаргажээ.

График.2.1.6



Шинжээчийн дүгнэлтийн 42 хувийг 1-3 шинжээч, 33 хувийг 4-6 шинжээч, 25 хувийг 7-9 шинжээчийн бүрэлдэхүүнтэйгээр гаргажээ.


График.2.1.7



Тус шүүхээс 2013-2015 онд шийдвэрлэгдсэн 13 хэрэгт томилогдсон шинжээчийн дүгнэлтийг шүүхийн шийдвэрийн үндэслэл болгосон байдлыг судалж үзэхэд 11 хэрэг буюу 84,6 хувьд нь шинжээчийн дүгнэлтийг шүүхийн шийдвэрийн үндэслэл болгож, шийдвэрийн үндэслэл хэсэгт дурдсан, 2 хэрэг буюу 15,3 хувьд шинжээчийн дүгнэлтийг шүүхийн шийдвэрийн үндэслэл болгоогүй байна. Шүүхээс томилогдсон шинжээчийн зардлыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу шийдвэрлэдэг бөгөөд тус шүүхээс шинжээчээр томилогддог этгээдийн онцлогтой холбоотойгоор /төрийн байгууллагаас томилогдсон шинжээч шинжээчийн зардал нэхэмжилдэггүй/ шинжээчийн дүгнэлтийн 56 хувь нь шүүхийн шийдвэрт тусгагдаагүй, 22 хувийг хариуцагчаар, мөн 22 хувийг нэхэмжлэгчээр төлүүлэхээр тус тус шийдвэрлэжээ.

### **Шинжээч томилоход учирч буй хүндрэл бэрхшээл, түүнийг шийдвэрлэх арга зам**

График.2.1.9




Захиргааны хэргийн шүүхийн хувьд харьяалан шийдвэрлэх маргааны төрлөөс шалтгаалан шинжээчээр томилох асуудал онцлогтой бөгөөд тухайн төрлийн маргаантай холбогдуулан Шүүхийн шинжилгээний байгууллагаар шинжилгээ хийх боломжгүй тохиолдолд уг асуудлыг хариуцсан мэргэжлийн байгууллагад хандах шаардлагатай болдог.

Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д “Шинжилгээг шүүхийн шинжилгээний байгууллагаас гадуур хийлгэх бол шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд шинжилгээ хийлгэх тухай тогтоол, захирамж, хүсэлт гаргаж, шинжилгээ хийхээр томилогдож байгаа шүүхийн шинжилгээний байгууллагад ажилладаггүй шинжээчийг дуудан ирүүлж, түүний биеийн байцаалт, мэргэжил, чадвартай танилцан, сэжигтэн, яллагдагч, хохирогчтой ямар харилцаатай болохыг тогтоохоос гадна шинжээчээс татгалзан гарах үндэслэл байгаа эсэхийг шалгана” гэсэн зохицуулалтын дагуу Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдал, Байгаль орчны яам, Газрын харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага буюу Засгийн газрын яам, агентлагуудаас шинжээчийг томилдог. Төрийн захиргааны байгууллага буюу мэргэжлийн агентлаг газруудаас шинжээч томилоход шинжээчээр томилогдсон төрийн албан хаагч үнсэн ажил, үүргээ гүйцэтгэхийн зэрэгцээ шүүхээс шинжээчээр томилогдон ажиллах нөхцөл, цаг хугацааны хувьд хүндрэл учирдаг.

Шүүхээс шинжээчээр томилогдсон төрийн байгууллагын ажилтан өөрийн үндсэн ажлын зэрэгцээ шүүхээс шинжээчээр томилогдсоны дагуу дүгнэлтийг гаргах ажиллагааг явуулдаг. Иймд шинжээчийн дүгнэлт тогтоосон хугацаанд гарахгүй байх сөрөг үр дагавар үүсгэж байгаагаас гадна тухайн ажилтны ажлын бус цагаар шинжээчээр ажилласан ажил үнэлэгдэхгүй байх тохиолдол нийтлэг байна. Дээр дурдсан төрийн байгууллагаас шинжээчээр томилогдсон шинжээч нар шинжээчээр ажилласан зардлыг гаргуулахаар шүүхэд хандаж ажилласан цагийн үнэлгээний тооцоог гаргаж ирүүлэх нь тохиолдол цөөн байдаг. 2013-2015 оны эхний хагас жилд 13 хэрэгт томилогдсон шинжээчийн зардлыг гаргуулахаар шүүхэд баримт, хүсэлтээ ирүүлдэггүйгээс 8 хэрэгт буюу 61 хувьд нь шинжээчийн зардал шийдвэрлэгдээгүй, 5 хэрэгт буюу 38,4 хувьд шинжээчийн зардлыг зохих хэргийн оролцогчоос гаргуулж, олгохоор шийдвэрлэжээ.

График.2.1.10



Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхээс шинжээчийн дүгнэлттэй холбоотой тулгамдсан асуудлыг шийдвэрлэхээр тодорхой арга хэмжээг авсны дотор Газрын харилцаа геодези зураг зүйн газартай /ГХГЗЗГ/ 2015 оны 6 дугаар сарын 29-ний өдөр Газрын маргаантай хэрэгт шинжээчийн дүгнэлт гаргах үйл ажиллагааг улсын төсөв болон төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хүндрэл учруулахгүйгээр зохион байгуулах харилцан мэдээлэл солилцох, тодорхой асуудлаар хамтарсан уулзалт,

сургалтыг хамтран зохион байгуулах зорилгоор хамтын ажиллагааны санамж бичгийг байгуулсан.

Уг санамж бичигт:

- Захиргааны хэргийн шүүх нь шинжээчийн дүгнэлт гарган хүргүүлэх хугацааг ажлын 15, нотлох баримт гарган хүргүүлэх хугацааг ажлын 5-10 өдрөөр тогтоож байх, ГХГЗЗГ нь шүүгчийн захирамжид заасан хугацаанд шинжээчийн дүгнэлт, нотлох баримтыг гарган хүргүүлэх;
- Захиргааны хэргийн шүүх нь шинжээчийн зардлыг шинжилгээ хийлгэхээр хүсэлт гаргасан хэргийн оролцогч /нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд/-оор урьдчилан төлүүлэх асуудлыг шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолоор шийдвэрлэж байх;
- Захиргааны хэргийн шүүх санаачлагаараа нотлох баримт цуглуулах үүргийнхээ дагуу ГХГЗЗГ-ыг шинжээчээр томилсон тохиолдолд шинжээчийн зардлыг төлүүлэх асуудлыг шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолоор шийдвэрлэх;
- Захиргааны хэргийн шүүх нь шинжээч томилсон шийдвэрийг агентлагт хүргүүлэхдээ шинжээчийн дүгнэлт гаргахад шаардлагатай баримтыг хуулбарлан хавсаргах, шинжээчийг хавтаст хэрэгтэй танилцах, хуулбарлан авах боломжоор хангах;
- ГХГЗЗГ нь энэхүү санамж бичигт зааснаас бусад тохиолдолд шүүхийн шийдвэрийн дагуу шинжээч томилсон шийдвэрийг тухайн хэрэгт шинжээчээр ажиллахад гарах зардлыг урьдчилан тооцсон тооцооны хамт шүүхэд ирүүлж, шинжээчийн зардал төлөгдсөн үед тогтоосон хугацаанд дүгнэлтийг гарган шүүхэд ирүүлэх;
- ГХГЗЗГ нь энэхүү санамж бичигт зааснаар шинжээчээр томилогдсон бол шинжээч томилсон захирамж, тогтоол ирсэн даруй шинжээчээр ажиллахад гарах зардлын тооцоог шинжээчийн дүгнэлттэй хамт шүүхэд хүргүүлэх зэрэг асуудлыг харилцан тохиролцсон.

Цаашид шүүхийн менежмент ялангуяа захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дахь шинжээчийн оролцоо, түүний үр нөлөөг сайжруулахад дээрх арга хэмжээ чухал бодлогын баримт бичиг болсон. Түүнчлэн шинжээч томилох ажиллагаа нь тус шүүхээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх үндэслэл болж, хэрэг шийдвэрлэгдэхгүй удаашрах нэг нөхцөл болж байна. 2015 оны эхний хагас жилийн байдлаар тус шүүхийн нийт түдгэлзүүлсэн 85 хэргийн 34 хэрэг нь буюу 40 хувь нь газрын маргаан, 16 хэрэг буюу 18.8 хувь нь улсын бүртгэлтэй холбоотой маргаан, 10 хэрэг буюу 11.7 хувь нь татварын маргаан, бусад маргаан тухайлбал ШӨХТГ-н улсын байцаагчийн акттай холбоотой, тендертэй холбоотой, төрийн албатай холбоотой маргаан 30 орчим хувийг тус тус эзэлж байна.

Нийт түдгэлзүүлсэн шалтгааныг авч үзвэл нийт 85 хэргээс 37 хэрэгт шинжээч томилсон, 29 хэрэг бусад иргэний болон эрүүгийн шүүхүүдэд хянагдаж буй хэргийг эцэслэн шийдвэрлэх хүртэл хугацаагаар, 10 хэрэг хэргийн оролцогч болох гуравдагч этгээдийг эрэн сурвалжлуулахаар, 3 хэрэг хэргийн оролцогч хүнд өвчтэй, 6 хэрэг хилийн чанадад нотлох баримт цуглуулах шаардлагатай, /өв нээгдэх эрх залгамжлагч томилох/ зэрэг шалтгаанаар түдгэлзүүлжээ. Иймд Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа олон төрлийн хэрэг маргааныг шийдвэрлэдэг онцлогт тохируулан шинжээч томилох ажиллагааг боловсронгуй болгох зайлшгүй шаардлагатай байна.











Өөрийн үйлдвэр, үйлчилгээний үйлдвэр, үйлчилгээний үйлдвэр 8 аорь 5.2 оорь, аорь 6.6 оорь 10 аорь 6.6 оорь оон оон үсүеэ ааея.

График.2.3.4



Үүдүүеэ иэдээийн аоний үйлдвэр, үйлчилгээний үйлдвэр, үйлчилгээний үйлдвэр 24 ооаа, Аоний үсүеэ, өөрийн үйлдвэр, үйлчилгээний үйлдвэр 3 ооаа, Ааеэ үйлдвэр, үйлчилгээний үйлдвэр 32 ооаа, Өөрийн үйлдвэр, үйлчилгээний үйлдвэр 1 ооаа өөрийн үйлдвэр.

График.2.3.5



Үүдүүеэ аон үйлдвэр, үйлчилгээний үйлдвэр, үйлчилгээний үйлдвэр 4 ооаа, аоний үйлдвэр, үйлчилгээний үйлдвэр 26 ооаа, аоний үйлдвэр, үйлчилгээний үйлдвэр 1 ооаа оон оон өөрийн үйлдвэр.

График.2.3.6



æодiaаd оyдyаæææ ааеia. Озгi-eyi æеяyу- iу yдo, ззdya, oadеooeaaуa iу odu-a-eeai naiooeaaazе ааeoaа азaйeoyу аадaаnai ааeо oioeieaie 2013 iia Aayiczdo азzdaeи ззoуa аадnai аaаoа oуdaeи ioeioia-iin æеяyу- yдo, ззdya, oadеooeaaуa iу odu-a-eeai naiooeaaazе ааeoaа азaйeoyу аадaаnai iу ззoеeи аeaaadae аeееeaaa aieini, yу iу ззoеeи æeaaaydo ioeeæ oooeu цoд-ни зiayneyeyyд iaдаaаi ззn- Edayiee oуdaeи ааæ çaaeaaд oаoiу 10 aaaaд ззoеeи 2014 iу 187 aaaaдoae iaаaaeaaд Aayiczdo азzdaeи ззoеeи 2013 iу 2607 aaaaдoae æeaaaydeea оз-eiaze aieainii oioeieaie аад-yу.

Oenui ayуa ззoуyн 2014 iу 12 aaaaд nadiу 23-iу oаo "Edayiee oуdya ззoуa oуiai æeaaaydeyо аeееeaaaia æеяyу-eei азaйeodeи oaeaad aioadao çadei anooae" aynyi цoaeoieea aadaanaa aа on цoaeoieei 4.4-o "Azayieoya çadei æеяyу- aadiу znya çodaaazе, oaiа, oуiaayyд aadaeaaaæooeaaazе аaeaae ззo yу oaeaad oiaдоoeæ, maadaeaaуa oaiaoeao adaa oуiaeyу aad iу oooeu цoд-eoazе pi" aynyi aaeaaa. Ay-a Edayiee oуdya ззoуa oуiai æeaaaydeyо oooae oooeei 47 aaaaд çzeeeи 47.2-o "Шинжэч шинжилгээ хийж дүгнэлт гаргахдаа Шзхийн шинжилгээний тухай хуульд заасан журмыг баримтална" гэж заасну ааоо Ozoeи æeæeayyiee oooae oooeei 9 азayyд çzeeeи 9.2-o çaaniad æеяyу-yyд oieeiaaio ydaayya yдo, ззdya, oadеooeaaуa iу odu-a-eeai naiooeæ aadiу znya çodooeinaad oooaei ydaayya æеяyу-yyд oieeiaaiaæ, æеяyу-eei азaйeо aadaa азdyi ydoeaa oуdyaæzeyo ydoye aaeoaad oooeu-eeni.

Eeia æеяyу- yдo, ззdyaoyeayy oaiеeoaazе, азaйeо aadaoaaн iу oio oadеooeaaуa iу odu-a-eeæ naiooeaaazе ааeoaа æеяyу-eei азaйeо aadaaæ аaeaaa oooeu iеeoyoaze ааeо ooe азaйeо aadaani aadaa oooeu çaani maadaeaaуa oaiaoeao adaa oуiaeyу aad iу oуdya oуiai æeaaaydeyо аeееeaaaaiу æodai цoд-eo ioeeae азdaazey. Oydaeи ioeioia-iin æеяyу- oieeooeadaad aadaaæ аaeaaa oznyeд, æеяyу-ea oaeo anooeд iу Edayiee oуdya ззoуa oуiai æeaaaydeyо oooae oooeei 47 aaaaд çzeea çaani onnae iyaeуa maadaeaaд anooae iу ynyд, oooaei anooeд iу æеяyу-ea oiaadao ynyд, çioe-a ioeiaie çioe anooaeaad æеяyу- oieeooeadaad oznyeд aadaanaa, oooaei oznyeд iу oуdya oiaadaeadae, a- oieaiaaieoie cydya ynydeea зz-a-eei çodeдаæ, ззoеeи oiaoinui ziayneyo oynya çaaaaazе, ззo/zz-a- zyeæ yaayyд ziayneyeeæ çaaeaaд, æеяyу- oieeio çaeewazе maadaeaaadae ynydeea oiaoinazeyayyд oznyeodeea ooa zeyyi a-a æеяyу- oieeini çadeдаæ oya oya oioeiaaæ аaeia. Ooaeaaaе, oydaeи ioeioia- aadaa anooaeуa oiaдоeadaad ззoуa oznyeд aadaaæ, ззo oznyeodeea oiaaæ æеяyу- oieeayy.

- a. "Aadaa-Ooe aeiaeeи Oiaid noiуi aoodo id-iui aadui oooeu ,niу ycyiea- iу yiaд aaeaoeaa aieio",
- b. "Oenui azdaayeeи -1317001576, -1317001714 aaaaд azdaayeye зe oaeo ooiiaazeeи азdoyaeeeи oaaeeи oуdya, ozziа oieaiaaio iioeio aadheidooa iу ya ooiiaeeи ydoeи oeni азdaayeeи oooae oooeei 17-d çzeea çaani maadaeaaуa oaianaa ynyд oaeaad Oenui azdaayeeи Adioee aadui oуiaeouи oeni aaeoaaa-aad oieaiaaio азaйeodeea aadaoeeæ oaiу zз"
- c. "Oyda onnae цoaeoaeazе zee аeееeaaa yaooeai aie yiaд oooeu oiaoinaeei çaeoua цoд-ни aieio",
- d. Oooeu oiaoinæ цoд-ни oioeiaaiea yiaд oadеooeaaa ozeyyeyo"
- e. "Aaaa oуaydeyо ooeoieeи оз-eи +aaeu oiaoinouи ooea zcyya, oodæeд oeeæ æеяyу-eei азaйeо aadaoeeæ oaiу zз" aynyi oznyeoya зz-a- ooiiaeeи zyeayyiee "AAIAI" ayya eiiiaieea æеяyу-yyд oieeayy.

Yayyд anooeodooaaaн "a" oioeiaaiea onnae iyaeуa maadaeaaadazе aaaa æеяyу- oa aad оyiee ycyiee aieioуa oiaoinazе, deei maadaeaaa aaeoazе, çioe-a ioeiaie çioe çzeea æеяyу- oieeooeadaad oznyeд aadaaniua aioadaaazе, "b", "c" aiei "d" oioeiaaiea







Судалгааны хүрээнд гадаадын зарим өндөр хөгжилтэй орнуудын шүүхийн шинжилгээний байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг өөрийн орны шүүхийн шинжилгээний байгууллагатай харьцуулан үзлээ. Эдгээрээс ОХУ, Эстон, Герман, Солонгос, зэрэг улсын шүүхийн шинжилгээний байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг өөрийн улсын шүүхийн шинжилгээний байгууллагын бүтэц, зохион байгуулалттай харьцуулан судлав. Судалсан улсуудын хөгжлийн хандлага, төрийн байгуулал, эрх зүйн тогтолцоо, оновчтой зохион байгуулалт зэргийг Монгол Улсын шүүхийн шинжилгээний байгууллагад туршлага судлах нэвтрүүлэх боломжтой гэж үзэн судлав. Оросын Холбооны Улс /ОХУ/-ын Дотоод хэргийн яам /ДХЯ/-ны шүүхийн шинжилгээний байгууллага 1919 оны 3 дугаар сарын 1-ний өдөр албан ёсоор байгуулагдсан байна. Энэ өдийг ОХУ-д бие даасан шүүхийн шинжилгээний байгууллага үүссэн гэж үздэг. 2003 оны 7 дугаар сараас ОХУ-ын ДХЯ-ны харьяа Криминалистикийн шинжилгээний төв болон өөрчлөгдсөн байна.

ОХУ-ын Хууль зүйн яамны харьяа Бүх холбооны шүүхийн шинжилгээний төвөөс гадна харьяат субъектуудад шүүхийн шинжилгээний чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж буй 100 гаруй шинжилгээний төв байна. Эдгээр төв нь Оросын ДХЯ-ны харьяа цагдаагийн байгууллагад харьяалагдан үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс гадна алслагдсан захиргааны нэгжүүдэд бие даасан шинжилгээний алба ажилладаг. ОХУ-ын ДХЯ-ны харьяа шинжилгээний байгууллагад 2014 оны байдлаар 15 000 орчим алба хаагч ажиллаж байна. ДХЯ-ны харьяа шинжилгээний алба нь дараах үндсэн чиглэл болон алба тасгуудтай байна. Үүнд:

- Галт зэвсгийн шинжилгээ;
- Тэсэрч дэлбэрэх бодис болон эд зүйлийн шинжилгээ;
- Үнэт цаас, бичиг баримт болон мөнгөн тэмдэгтийн шинжилгээ;
- Фото зураг, дүрс бичлэгийн шинжилгээ;
- Мөр судлалын чиглэл;
- Авто техник шинжилгээ;
- Компьютер техникийн шинжилгээ;
- Гарын хээний шинжилгээ;
- Шүүх эмнэлгийн шинжилгээ;
- Биологийн эдийн шинжилгээ;
- Ургамал болон эрдэст газрын шинжилгээ;
- Шүүх эдийн засгийн;
- Нягтлан бүртгэлийн гэсэн чиглэлээр шинжилгээ явуулж байна.<sup>20</sup>

Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын шинжилгээг мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодистой тэмцэх тусгай алба хариуцан ажилладаг. ОХУ-ын ДХЯ-ны төв аппарат нь 9 удирдах газар, 8 ерөнхий газар, 11 газар, 15 төвтэй бөгөөд төвүүдийн нэг нь Криминалистикийн шинжилгээний төв юм. Тус төвд криминалистикийн бүх төрлийн шинжилгээг хийхээс гадна бүс нутаг дахь газар, хэлтсүүдийн криминалистикийн шинжилгээний нэгжүүдийн үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих, мэдээлэл, арга зүй, техник хэрэгслээр хангах үүрэгтэй.

Криминалистикийн шинжилгээний төвийн үйл ажиллагааны чиглэл нь:

- Нутаг дэвсгэрийн криминалистикийн шинжилгээний албадын шинжилгээ хийхтэй холбоотой үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;
- Цагдаагийн байгууллагын явуулж буй гүйцэтгэх ажил болон мөрдөн байцаалтын ажиллагаанд мэргэжилтэн оролцуулах ажлыг зохион байгуулах;

<sup>20</sup> <http://www.zakonprost.ru/content/base/58619>


- Криминалистикийн шинжилгээний бүртгэлийг явуулах болон ашиглах ажлыг зохион явуулах;
- Шинжилгээний үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж болон эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар судалгаа шинжилгээ хийх, харьяа шинжилгээний албыг удирдлагаар хангах;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийг илрүүлэх, мөрдөх ажлын хүрээнд цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд тусгай мэдлэг ашиглаж, цаашид үйл ажиллагаандаа хэрэглэх чиглэлээр судалгаа явуулах, криминалистикийн шинжилгээний үйл ажиллагаанд тусгай салбар шинжлэх ухааны нэвтрүүлэх, судалгаа хийх зэрэг болно.<sup>21</sup>

ОХУ-ын криминалистикийн шинжилгээний төвийн үйл ажиллагаа нь ОХУ-ын Үндсэн хууль, Холбооны Үндсэн хууль, Холбооны хууль тогтоомжоор зохицуулагдахаас гадна ДХЯ-ны сайдын тушаалын үндсэн дээр явагддаг. ОХУ-ын Муж улсууд дахь салбар нь тухайн муж улсын цагдаагийн байгууллагын харьяанд үйл ажиллагаагаа явуулах бөгөөд цаашид Криминалистикийн шинжилгээний төв гэнэ. Төвүүдийн удирдлага болон бүтэц нь ДЯЯ-ны сайдын тушаалаар батлагдахаас гадна үйл ажиллагааг тухайн муж улсын цагдаагийн байгууллагын даргын тушаалаар зохицуулагдана. Муж улсын Криминалистикийн шинжилгээний дарга нь ДХЯ-ны сайдын тушаалаар томилогдож, чөлөөлөгдөнө. ОХУ-ын Прокурорын байгууллага тодорхой төрлийн гэмт хэргүүдийг мөрдөн шалгах үүрэгтэй бөгөөд тэдгээрийн бүтэцэд шүүхийн шинжилгээний нэгж байдаг<sup>22</sup>. ОХУ-ын ДЯЯ-ны харьяа Криминалистикийн шинжилгээний төв нь төрийн байгууллага юм. ОХУ-ын ДХЯ-ны Криминалистикийн шинжилгээний төв нь шүүхийн шинжилгээ, криминалистикийн үйл ажиллагааны чиг үүргийг биелүүлдэг.




#### Дотоод хэргийн яамны бүтэц







ОХУ-ын ДХЯ-ны Криминалистикийн шинжилгээний төвийн бүтцийн схем



**-“ОХУ-ын Төрийн шүүх-шинжилгээний үйл ажиллагааны тухай хууль”-д  
хийсэн судалгаа**

Тус хууль нь 2001 оны 5 дугаар сарын 31-ний өдөр батлагдсан ба 6 бүлэг 43 зүйлтэй. Үүнд:

- Нэгдүгээрт бүлэг: Нийтлэг үндэслэл /13 зүйлтэй/,
- Хоёрдугаар бүлэг: Төрийн шүүх-шинжилгээний байгууллагын дарга, шинжээчийн эрх, үүрэг /5 зүйлтэй/;
- Гуравдугаар бүлэг: Төрийн шүүх-шинжилгээний байгууллагад шүүх шинжилгээ хийх ажиллагаа /7 зүйлтэй/;
- Дөрөвдүгээр бүлэг: Төрийн шүүх-шинжилгээний байгууллагад амьд хүний биед хийх шүүх шинжилгээний онцлог /11 зүйлтэй/;
- Тавдугаар бүлэг: Төрийн шүүх-шинжилгээний байгууллагын санхүүгийн, зохион байгуулалтын, шинжлэх ухаан-арга зүйн болон мэдээллийн хангамж /4 зүйлтэй/;
- Зургадугаар бүлэг: Бусад зүйл: /3 зүйлтэй/.

Энэ хуулийн гол зорилго нь эрүү, иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх явцад төрийн шүүх шинжилгээний байгууллагын хийж буй шүүх шинжилгээний үйл ажиллагааны эрх зүйн үндэс, зохион байгуулалтын зарчим, үндсэн чиглэлийг тодорхойлоход оршино. Харин төрийн бус шүүх шинжилгээний байгууллагын үйл ажиллагааны талаар зүйл, заалт ороогүй байна. ОХУ-ын Төрийн шүүх-шинжилгээний үйл ажиллагааны тухай хууль нь Монгол Улсын Шүүхийн шинжилгээний тухай хуультай агуулга, бүтцийн хувьд ижил төсөөтэй зүйл их байна. Гэвч манай хууль тогтоомжид байхгүй дараах онцлогууд ОХУ-ын хуульд туссан байна. Үүнд:

1. Шинжилгээний байгууллагын дарга, түүний эрх, үүрэг. Шүүх шинжилгээний байгууллагын дарга шинжилгээ хийх үйл ажиллагаанд хэрхэн оролцох, даалгах, шинжилгээг зогсоох, бусад байгууллагатай хэрхэн хамтарч ажиллах, даргад тавих хязгаарлалт зэргийг нэг бүрчлэн задалж хуульчилжээ. Харин манай орны шүүх шинжилгээний байгууллагын дарга хууль зүйн хувьд шинжилгээ хийж буй ажиллагааг мэргэжлийн хувьд хянан зөвлөх, зааварчлаг өгөх зэрэг эрх байдаггүй. Ийм эрхгүйгээс болж манай орны шинжилгээний албаны шат, шатны дарга нар мэргэжил, арга зүйн хувьд шинжээчид зөвлөгөө өгвөл “хууль бус ажиллагаанд” тооцогдох юм. Түүнчлэн даргын шинжээчтэй харьцах зарим эрх хэмжээг хуулиар хязгаарлаж өгөхгүй бол шинжээчийн хараат бус байх зарчим, шинжилгээнд бодитой хандах зэрэг зарчим зөрчигдөхөд хүрэх юм.

2. Шинжээчид тавих шалгуур, мэргэжлийн бэлтгэлийн түвшин тогтоох, эрх олгох, аттестатчилах асуудал. Төрийн ямар түвшний байгууллагад ямар боловсролын зэрэгтэй шинжээч ажиллах, ямар мэргэжлийн бэлтгэл хангасан шинжээч шинжилгээ хийх, ямар хугацаанд хэн, хэрхэн аттестатчилах тухай заасан байна. Манай орны хувьд ийм зохицуулалт байхгүй. Шинжээчид сургууль төгсөнгүүтээ бүх төрлийн шинжилгээ хийж дүгнэлт гаргаж байна. Уг нь шинжээч шинжилгээний аль нэг төрөл болон хэд хэдэн төрлөөр мэргэшиж байж тухайн дүгнэлт шинжлэх ухааны шалгуурыг хангана гэсэн үг. Жишээ нь: зүрхний мэс заслаар нарийн мэргэшиж сураагүй, лицензгүй эмч зүрхний мэс засаж хийж байгаатай адил юм. Монгол Улсын шүүхийн шинжилгээний байгууллагад шинжлэн магадлах ухааны боловсрол эзэмшсэн байдлаараа 2 төрлийн шинжээч ажиллаж байна. Нэгдүгээрт: Хууль сахиулахын их сургууль төгссөн криминалистикийн шинжээч, Хоёрдугаарт: иргэний их, дээд сургууль төгссөн мэргэжилтэнг шинжээчээр ажиллуулж байна. ХСИС төгссөн шинжээч бол шинжлэн магадлах ухааны онол, мөр судлал, хэргийн газрын үзлэг, эрүүгийн болон эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй, гүйцэтгэх ажил зэрэг

мэргэшүүлэх хичээлийн хөтөлбөрийг дүүргэсэн байдаг. Тийм байсан ч гэсэн сургууль төгсөөд өөрийнхөө мэргэших шинжилгээний төрлийг сонгон гүнзгийрүүлэн суралцаж, шалгалт өгч тэнцсэн тохиолдолд дүгнэлт гаргах эрх үүсэх ёстой. Харин иргэний их, дээд сургууль төгссөн мэргэжилтэн ШШҮХ-нд шинжээчээр ажиллах тохиолдолд эхний ээлжид заавал ХСИС-д шинжлэн магадлах ухааны онол, мөр судлал, хэргийн газрын үзлэг, эрүүгийн болон эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй, гүйцэтгэх ажил зэрэг хууль сахиулах үйл ажиллагааны үндэс, шинжилгээний онол, арга зүйг эзэмшин, шалгалт өгсний дараагаар шинжээчээр томилогдож дүгнэлт гаргах эрхтэй болох юм.

3. Амьд хүнд сайн дурын болон албадлагын журмаар шинжилгээ хийх. Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хангахтай холбоотойгоор шинжилгээ хийх явцад хүнтэй харьцах тодорхой хязгаарлалтуудыг хуульчилсан байна.

4. Шинжилгээний байгууллага, шинжээчийн хараат бус байх зарчмыг дэлгэрэнгүйгээр зааж өгсөн. Монгол Улсын Шүүхийн шинжилгээний тухай хуульд хараат бус байх асуудлыг ганцхан 4 дүгээр зүйлийн 4.1.3-т заасан байгаа нь хангалтгүй юм. Тусдаа зүйлээр хэд хэдэн заалттай байхаар хуульчлах нь шинжээчийн дүгнэлтийн нотлох баримтын ач холбогдлыг сайжруулж, шинжээчийн аюулгүй байдал, нийгэм, эдийн засгийн баталгааны үндэслэлийг нэмэгдүүлэх юм.

5. Шинжилгээний явцад хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хангах зарчмыг маш тодорхой болгосон байна. Хүний эрхийн байгууллагууд болон хүний эрхийг хязгаарлах эрх бүхий субъектүүд шүүх шинжилгээг хүний эрхийг хамгаалахад ашиглаж байгаа байдал манай орны хувьд дутагдалтай байдаг. Ер нь энэ тухай мэдлэг, мэдээлэл, арга зүйн талаарх ойлголт манай орны хуульчид, хүний эрхийг хамгаалагчдад туйлын хангалтгүй байна. Шүүх шинжилгээ зүй үүссэн гол хүчин зүйл, шалтгаан нь хүний эрхийг хамгаалах явдал байсан юм.

6. Нэг чиглэлийн шүүхийн шинжилгээний байгууллагууд хамтарч ажиллахаар бол шинжлэх ухааны хандлага, мэргэжлийн бэлтгэл, шинжээчдийн мэргэшил ижил байхаар хуульчилсан. Энэ нь шинжлэх ухааны ижил түвшний нэг аргаар, нэг стандартаар шинжилгээ хийх эрх зүйн үндэс болж байгаа юм. Хоорондоо шинжлэх ухааны маргаан гаргахгүйгээр дүгнэлтэд хүрнэ гэсэн үг.

7. Орон нутгийн шинжилгээний байгууллага нь тухайн нутаг дэвсгэрийн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, прокурор, шүүхийн даалгасан шинжилгээг заавал хийх зарчимтай ба боломжгүй бол өөр нутаг дэвсгэрийн шинжилгээний байгууллагаар хийлгэж болохоор зааж өгсөн. Манай орон нутгийн шүүхийн шинжилгээний алба зарим төрлийн шинжилгээг боловсон хүчин, техник хэрэгслийн хомстлоос болж хийдэггүй байдал ажиглагддаг. Хэрэв Монгол Улсын Шүүхийн шинжилгээний тухай хуульд орон нутгийн шинжилгээний байгууллага нь тухайн нутаг дэвсгэрийн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, прокурор, шүүхийн даалгасан шинжилгээг заавал хийх зарчмыг тусгаж өгвөл аймаг, нийслэлийн шүүхийн шинжилгээний алба хөгжих, бэхжих эрх зүйн үндэслэл болж өгнө.

### **3.2 Эстон Улсын шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцоо, эрх зүйн орчин, шинжилгээний төрөл**

Бүгд Найрамдах Эстон Улс (БНЭУ)-ын шүүхийн шинжилгээний байгууллага нь 1938 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн Шүүхийн тогтоолоор байгуулагдсан. 1945 оны эхээр шүүхийн шинжилгээг цагдаагийн байгууллагын гэмт хэрэг мөрдөн шалгах ажиллагаанд явуулах болсон. БНЭУ-ын Шүүх эмнэлгийн товчоо болон Шүүхийн шинжилгээний төвийг 2008 онд БНЭУ-ын Хууль зүйн яамны агентлаг болгон нэгдсэн зохион байгуулалтад оруулж, “Шүүхийн шинжилгээний хүрээлэн” нэртэйгээр байгуулсан. Тус хүрээлэн нь Шүүхийн шинжилгээний тухай хуулийн дагуу үйл ажиллагаа явуулдаг. Одоогийн байдлаар

тус хүрээлэнд 45 орчим төрлийн шинжилгээ хийдэг байна. Шүүхийн шинжилгээний төв нь 1996 оны үед БНЭУ-д үйлчилгээ үзүүлэх боломжтой шүүхийн шинжилгээний төв байгууллага байжээ.

Шүүхийн шинжилгээний салбарын үйл ажиллагааг зохицуулж байсан хэд хэдэн хууль тогтоомжоос үүдэн гарсан зөрчилдөөний эцэст байгууллагуудыг дахин зохион байгуулж, бүтцийн өөрчлөлт хийсэн нь БНЭУ-ын шүүхийн шинжилгээний салбарын түүхэнд чухал байр суурь эзэлсэн гэж үздэг. Салбарын тогтвортой байдлыг хадгалахын хамт шүүхийн шинжилгээний үйл ажиллагааг нэг мөр болгох, шинжээчдийн эрх зүйн байдлыг тогтоох, албан ёсоор баталгаажсан, шинжээчдийн мэдээллийн баазыг бий болгож, мэргэжилтнүүдийн үйл ажиллагааг баталгаажуулах, зохицуулах шаардлага өсөн нэмэгдсэн. Шинжлэх ухаан техникийн өндөр хөгжлийг хамаарсан шинжилгээг хийх, зохицуулах, хуулийн үр өгөөж, хүчин төгөлдөр байдлыг батлах нь туйлын чухал байсан.

Шүүхийн шинжилгээний хуулийг боловсруулах ажил 1996 онд эхэлсэн бөгөөд тус хууль 2001 оны 5 дугаар сарын 30-ны өдөр батлагдсан. БНЭУ-ын “Шүүхийн шинжилгээний тухай хууль” 2002 оны 1 дүгээр сарын 1-ээс хүчин төгөлдөр болон мөрдөгдөж эхэлжээ.<sup>23</sup> Тус хүрээлэнд нь албан ёсны гэрчилгээ бүхий 60 орчим мэргэжилтнүүдийн жагсаалт байдаг ба эрх бүхий этгээд хуулийн дагуу шинжээчээр томилж болдог. Эрх бүхий этгээдэд цагдаа, шүүгч, прокурор, бүхий л төрлийн мөрдөн байцаах байгууллагын мэргэжилтэн хамаарна. Шүүхийн шинжилгээний хүрээлэн өөрийн үйл ажиллагааг Европын Холбооны шүүхийн шинжилгээний үйл ажиллагааны зарчимд нийцүүлэн явуулдаг. БНЭУ-ын шүүхийн шинжилгээний хүрээлэн нь үйл ажиллагаагаа шударга зарчимд нийцүүлэн явуулдаг ба шинжилгээг олон стандартын дагуу хийн дүгнэлт гаргадаг. Хүрээлэн нь бүтцийн хувьд 16 хэлтэст хуваагддаг бөгөөд нийт 169 алба хаагчтай үүнээс 89 нь шинжээч, мэргэжилтэн байдаг. Тус хүрээлэн нь хэд хэдэн төрлийн олон улсын стандартыг мөрдлөг болгон үйл ажиллагаа явуулдаг. Үүнд:

- EVS-EN ISO / IEC 17025 стандарт
- EVS-EN ISO / IEC 17020 стандарт
- EVS-EN ISO 9001 чанарын менежментийн стандарт

2003 онд Эстон Улсын итгэмжлэлийн төвөөр ISO17025 чанарын гэрчилгээ авч итгэмжлэгдсэн ба дараах шинжилгээний төрлөөр шинжилгээ хийж байна.


- Хор судлал;
- Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисыг тогтоох;
- Галт зэвсэг ба электрон микроскоп;
- ДНХ-ийн шинжилгээ;
- Масс хэмжилтийн шинжилгээ;
- Мөнгөн дэвсгэртийн шинжилгээ;
- Хурууны хээний шинжилгээ зэргийг хийх болсон.

Мөн 2009 онд № EST90645A дугаартай гэрчилгээ авч, Олон улсын чанарын ISO 9001 стандартыг удирдлага болгон шүүхийн шинжилгээний дүгнэлт гаргахтай холбоотой үйл ажиллагаанд ашигладаг. Хүрээлэнгийн шинжээчид шинжилгээ хийхээс гадна олон салбарын шинжлэх ухаанд суурилсан судалгаа хийн шинэ арга технологи нэвтрүүлэн ажилладаг. Эстон Улсын шүүхийн шинжилгээний хүрээлэн нь Европын шүүхийн

<sup>23</sup> <http://www.ekei.ee/en/efsi-organization>.

шинжилгээний холбоо (ENFSI), Олон улсын шүүх хор судлалын холбоо (TIAFT), Европын шүүх эмнэлгийн холбоо, Олон улсын шүүхийн генетикийн нийгэмлэг (ECLM), Балтын Криминалистикийн хүрээлэнгийн холбоо (NBFSI) зэрэг олон улсын байгууллагуудтай хамтарч ажилладаг.

**БНЭУ-ын шүүхийн шинжилгээний хүрээлэнгийн бүтцийн схем<sup>24</sup>**



**БНЭУ-ын “Шүүхийн шинжилгээний тухай”-хууль**

БНЭУ нь Шүүхийн шинжилгээний тухай хуультай Европын цөөн улсын нэг юм. Эстон Улс шүүхийн шинжилгээний хууль батлан мөрдөж байх үед Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Франц, Австри улсад ч энэ салбарын хууль тогтоомжийг боловсруулах үйл явц өрнөж байжээ. Шүүхийн шинжилгээний хууль боловсруулах гол зорилго нь:

<sup>24</sup> <http://www.ekei.ee/en/efsi-organization>



1. Шинжээчийн эрх зүйн байдлыг тодорхойлох, шүүхийн шинжилгээний үйл ажиллагааг нэг мөр болгох, албан ёсоор зөвшөөрөгдсөн шинжээчдийн мэдээллийн баазыг бий болгож, шүүхийн шинжилгээний нийгэм дэх байр суурийг хангах;
2. Буруутай этгээдээс шүүхийн шинжилгээний зардал гаргуулах систем бий болгосноор засгийн газрын зардлыг бууруулах.

Тус хууль нь 6 бүлэг 31 зүйлтэй.

Нэгдүгээрт бүлэг: Ерөнхий зүйл /4 зүйлтэй/,  
Хоёрдугаар бүлэг: Шүүхийн шинжээч болон шинжилгээний байгууллага /5 зүйлтэй/,  
Гуравдугаар бүлэг: Улсын магадлан итгэмжлэлтэй шинжээч /12 зүйлтэй/,  
Дөрөвдүгээр бүлэг: Шинжээчийн эрх ба үүрэг /4 зүйлтэй/,  
Тавдугаар бүлэг: Шинжилгээний санхүүжилт /2 зүйлтэй/,  
Зургадугаар бүлэг: Хуулийн хавсралт /3 зүйлтэй/.

БНЭУ-ын “Шүүхийн шинжилгээний тухай хууль” нь Монгол Улсын Шүүхийн шинжилгээний тухай хуультай агуулга, бүтцийн хувьд ижил төсөөтэй зүйл их байх боловч зарим нэг шинэлэг зүйл ажиглагдаж байна. Үүнд: Уг хуулийн 3 дугаар бүлгийн 10 дугаар зүйлд магадлан итгэмжлэлтэй шүүхийн шинжээчийн эрх зүйн байдлыг тусгаж өгсөн байна. Магадлан итгэмжлэлтэй шүүхийн шинжээчийг хуульд заасан шаардлагын дагуу нэрсийн жагсаалтад оруулахдаа хийж байгаа шинжлэх ухааны шинжилгээний салбарын хүрээнд бүртгэдэг байна.

### **3.3 Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцоо, эрх зүйн орчин, шинжилгээний төрөл**

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны чиглэлээр шүүхийн шинжилгээ, шүүх эмнэлгийн шинжилгээ явуулдаг. Холбооны улсын Дотоод хэргийн яам (ДХЯ)-ны харьяанд байх Холбооны Эрүүгийн Цагдаагийн ерөнхий газар (ВКА буюу *Bundeskriminalamt*) болох муж улсуудын Эрүүгийн цагдаагийн газруудад (ЛКА буюу *Landes Kriminal Amt*) шүүхийн шинжилгээ хийдэг.<sup>25</sup> ВКА буюу Холбооны эрүүгийн цагдаагийн газар нь 9 хэлтэстэй. Түүний нэг нь криминалистикийн техникийн институт (Das Kriminaltechnische Institut) юм. Энэ институтэд:

- Химич
- Физикч
- Биологич
- Инженер
- Утасны мэргэжилтэн
- Физиологич
- Хэл судлаач
- Эм зүйч
- Эрдэс судлаач
- Мэдээлэлийн технологийн мэргэжилтэн

<sup>25</sup> www.bka.de

- Электроникч
- Техникийн мэргэжилтэн
- Туслах болон лаборант зэрэг 60 гаруй мэргэжлийн 300-аад хүн ажилладаг.

Эдгээр мэргэжилтэнгүүд шүүхийн /forensic/ шинжилгээ хийхээс гадна гадаад, дотоод болон муж, дүүргийн эрүүгийн цагдаа нарт чиглэл тус бүрээр сургалт явуулдаг. ВКА буюу Холбооны эрүүгийн цагдаагийн газрын хуульд ВКА-ийн бүтцийн талаар байдаггүй бөгөөд байгууллагын эрх хэмжээ, үйл ажиллагааны чиглэл, хамрах хүрээ, мужийн Эрүүгийн цагдаагийн газар, олон улсын ижил төстэй байгууллагуудтай хэрхэн хамтран ажиллах, хувь хүнтэй холбоотой нууцлал, мэдээллийн сангийн талаарх үйл ажиллагааг зохицуулсан байдаг.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс /ХБНГУ/-д Шүүхийн шинжилгээний байгууллагын тусгай хууль байдаггүй тул тус байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааг журмаар зохицуулдаг. Эрүүгийн цагдаагийн газрын /ВКА/-ийн хариуцсан асуудалд олон улсын зохион байгуулалттай гэмт хэрэг, галт зэвсэг наймаалах, тэсэрч дэлбэрэх бодис, мансууруулах бодис хил давуулан борлуулах, хуурамч мөнгөн дэвсгэрт үйлдэх, төрийн зүтгэлтний амь нас, эрүүл мэндэд улс төрийн сэдэлтээр халдсан гэмт хэргүүдэд хэрэг бүртгэл, мөрдөн байцаалт явуулах, шүүхэд шинжээч, мэргэжилтнийг явуулах зэргээр оролцдог. Үүнээс гадна дотоод хэргийн сайдын хүсэлт, даалгавар улсын ерөнхий прокурор болон дээд байгууллагын хүсэлт болон даалгавараар хэргийн газар ажиллах, тусгай мэдлэгийн мэргэжилтэн хэрэгтэй үед шинжээч илгээх, оролцох, ихэнхдээ шинжээчээр ажиллах, дүгнэлт гаргаж өгөх үүрэгтэй байдаг.<sup>26</sup>

Нийт 20 орчим шинжилгээний чиглэл бүхий салбаруудтай.<sup>27</sup> Үүнд:

- Физик
- Хими
- Биологи
- ДНХ-ийн
- Бичиг баримтын
- Техникийн
- Дуу авиа таних
- Бичгийн хэлбэр хэвийн гэх мэт

Жилд 14000 гаруй шинжилгээний тайлан, шинжээчийн дүгнэлтийг шүүхэд гаргадаг, ялангуяа дэлхийн бусад орны эрүүгийн цагдаагийн газруудад /энэ нь иргэний цагдаа байж болох/ шинжээчээр ажиллаж, шинжээчийн дүгнэлт гаргаж өгдөг.<sup>28</sup> ВКА нь шүүхийн шинжилгээний чиглэлээр (forensic science гэдэг утгаараа) ХБНГУ-дганцтөв нь төдийгүй, хамгийн том судалгаа, шинжилгээний байгууллага бөгөөд бусад бүх мужийнхаа орон нутгийн цагдаагийн газрын шинжээчидтэй хамтарч ажилладаг. Мьюнштэрн хотод байдаг Германы Цагдаагийн дээд сургуультай нягт хамтын ажиллагаатай. ВКА нь судалгаа шинжилгээний үр дүн, шүүхээр шийдэгдсэн тодорхой эрүүгийн хэргүүдтэй холбоотой

<sup>26</sup> [http://www.bka.de/profil/bka\\_organigramm.pdf](http://www.bka.de/profil/bka_organigramm.pdf)

<sup>27</sup> 20 Untersuchungsbereichen B. Physikalisches und Chemisches Zentrallabor, Ballistik, DNA-Analytik, Urkundenprüfung, Sicherheitstechnik, Sprechererkennung, Handschriften-Untersuchung

<sup>28</sup> <http://dict.leo.org/>

шинжилгээний үр дүнгийн зарим хэсгээс олон нийтийн хэвлэл, мэргэжлийн ном, гарын авлага зэрэгт нийтлүүлдэг<sup>29</sup>.

Мужийн эрүүгийн цагдаагийн газрын шинжилгээний хэлтэс нь:

1. Чанарын менежмент;
2. Криминалистик техникийн институт;
3. Мэргэжлийн төв албатай;

Шинжээчид нь дараах мэргэжлийн салбар хэсгүүдэд хуваагддаг.

1. Нэгдүгээр хэсэг:

- Материалын шинжилгээ;
- Физик, ерөнхий хими;
- Биологи, ул мөр судлал;
- Бичгийн хэв, бичиг баримт;
- Буу, галт зэвсэг, баллистик шинжилгээ, хэв хэлбэр авах.

2. Химийн болон техникийн шинжилгээний хэсэг:

- Гал түймрийн шалтгаан;
- Тэсэрч дэлбэрэх бодис;
- Хор, хортой зүйлс.

3. Гуравдугаар хэсэг:

- Молекул генетикийн шинжилгээ;
- ДНХ-цусны;
- ДНХ-ул мөрний;
- DANN-data-base /мэдээллийн сан/.

4. Дөрөвдүгээр хэсэг:

- Танин олуулах шинжилгээ;
- Дактилоскоп адилтгал;
- Хэргийн газрын мэргэжлийн баг буюу жижүүрийн бүрэлдэхүүн гэсэн бүтэцтэй

байдаг.

Эдгээр үйл ажиллагааг тухайн муж улсын хуулиудаар зохицуулсан байдаг ба хуулиндаатовчтодорхой эрх зүйн үндсийг тусгаж түүнийгээ тушаал журам хэлбэрээр дэлгэрүүлэн хэрэгжүүлдэг. ХБНГУ-д шинжээч болоход төрийн байгууллагад ажилладаг нарийн мэргэжлийн албан хаагчид эрх, үүргийнхээ дагуухуульдзааснаар төрөөс томилогдсон эсвэл шинжээчийн эрхийн шалгалт өгч тангараг өргөн шинжээч болдог. Шинжээч нь салбарынхаа хамгийн дээд мэргэжлийн байгууллагад шалгалт өгч тангараг өргөн сертификат авдаг. Сертификат өгсөн байгууллагаас эргэж эрхийг нь хасах, түдгэлзүүлэх эрхтэй байдаг. Эдийн засаг, банк санхүү, нягтлан бодох бүртгэл үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, хөдөө аж ахуйн үнэлгээ, гэх мэт маш олон чиглэлээр шалгалт авч эрхийг нь олгож, нутаг дэвсгэрийн хязгаарлалт, томилгоо хийдэг.

Дээр дурдсан бүх асуудал салбар тус тусынхаа хуулиар зохицуулагдсан байдаг. Тухайлбал, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, төрөөс эрх олгосон шинжээчийн тухай хууль /энэ нь бүх төрлийн шинжээчийн/, Шүүхийн тухай хууль, Насанд хүрээгүй хүмүүсийн шүүхийн тухай хууль, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх хууль тус бүрдээ шинжээчийн үйл ажиллагааг зохицуулсан байдаг.

<sup>29</sup> [http://www.lka-bw.de/download/Organigramm\\_LKA.pdf](http://www.lka-bw.de/download/Organigramm_LKA.pdf)

### 3.5. Бүгд Найрамдах Солонгос Улсын шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцоо, шинжилгээний төрөл

Бүгд Найрамдах Солонгос Улс /БНСУ/-ын шүүхийн шинжилгээний төв байгууллага нь Шүүхийн шинжилгээний хүрээлэн юм. 1955 оны 3 дугаар сарын 25-ны өдөр Дотоод хэргийн яаманд байгуулагдсан. Тус алба нь одоо Аюулгүй байдал, нийтийн захиргааны яамны нэг агентлаг юм. Тус агентлагийн зэрэгцээ Дээд прокурор, Цагдаагийн газрын дэргэд шүүхийн шинжилгээний нэгж ажилладаг. Мөн Их сургуулиудын лабораторид зарим төрлийн шинжилгээ хийдэг.<sup>30</sup> БНСУ шүүхийн шинжилгээний албаа бүсчлэн байгуулсан байдаг бөгөөд Сөүл, Тэжон, Гуанжу, Тэгү, Пусан хотод байдаг.


Шүүхийн шинжилгээний алба нь дараах бүтцээр шинжилгээ хийж байна.

1. Шүүх ДНХ-ийн хэлтэс:
  - ДНХ-ийн шинжилгээ;
  - ДНХ-ийн индекс;
  - ДНХ-ийн бүртгэл мэдээлэл.
2. Эм судлал, хор судлалын шинжилгээний хэлтэс:
  - Эм судлал;
  - Хор судлал;
  - Хүнсний бүтээгдэхүүн.
3. Химийн шинжилгээний хэлтэс:
  - Химийн найрлага тогтоох;
  - Цусан спиртийн хэмжээ тогтоох;
  - Металын бүтэц тогтоох.
4. Шүүх аюулгүй байдлын хэлтэс:
  - Инноваци, аюулгүй байдал;
  - Инноваци, ослын шалгаан;
  - Инноваци болон дэлбэрэлт галын шалтгаан судлал;
  - Инноваци, галт зэвсэг, цусан мөр судлал.
5. Дижитал технологи, Биометрийн шинжилгээний хэлтэс:
  - 2D/3D Био-дата харьцуулалт;
  - Дуу хоолойн харьцуулалт;
  - Аудио-медиа;
  - Гар утасны дууны шинжилгээ.
6. Зам тээврийн ослын шинжилгээний хэлтэс:
  - Тээврийн хэрэгслийн өөрчлөлтийн шинжилгээ;
  - Ослын шалтгаан нөхцөл.
7. Шүүх сэтгэл судлалын шинжилгээний хэлтэс:
  - Шүүх сэтгэц
8. Шүүх эмнэлгийн шинжилгээний хэлтэс:
  - Задлан шинжилгээ;
  - Шүүх эд судлал;

<sup>30</sup> <http://www.nfs.go.kr:8080/branchSeoul.action>.

- Шүүх шүд судлал;
9. Үхлийн шалтгаан.<sup>31</sup> гэсэн төрлүүдээр үйл ажиллагаа явуулдаг.

БНСУ-ын Шүүхийн шинжилгээний шинжилгээний бүтцийн схем



Тус албанд 2014 онд хийсэн шинжилгээг томилсон байгууллагаар харуулбал:


Жил	Нийт	Цагдаа	Тэнгисийн цагдаа	Шүүх	Прокурор	Цэргийн хүчин	Бусад
2004	220,698	210,588	2,522	824	4,596	582	1,586
2005	208,193	199,207	2,506	719	3,548	1,249	964
2006	211,934	201,302	3,336	637	3,126	1,021	2,512
2007	224,589	213,259	2,760	486	3,245	1,108	3,731
2008	256,386	243,813	3,418	554	3,046	755	4,800

<sup>31</sup> <http://www.nfs.go.kr:8080/organization.action>



<b>2009</b>	278,040	264,982	3,741	824	3,253	391	4,849
<b>2010</b>	276,614	262,816	3,767	847	2,851	485	5,848
<b>2011</b>	297,357	276,536	4,188	473	8,494	1,038	6,628
<b>2012</b>	297,698	283,854	5,389	776	3,605	435	3,639
<b>2013</b>	335,009	316,807	6,886	1,589	4,695	351	4,681
<b>2014</b>	348,117	331,175	5,069	4,669	1,600	1,246	4,35

Тус албаны алба хаагчдын тоо:<sup>32</sup>



БНСУ шүүхийн шинжилгээний байгууллагын төрөлжсөн хууль байхгүй бөгөөд дээд байгууллагын даргын тушаалаар батлагдсан дүрэм, журмаар зохицуулагддаг. Хэргийн газрын үзлэгээр ул мөр цуглуулах, хэргийн газрын гэрэл зураг авах, шуурхай эрэн сурвалжлах зорилгоор гарын мөр, хонгио, хошуу, эзэнгүй цогцосны мэдээллийн сан бүрдүүлж ашиглах ажиллагааг нь цагдаа, хэрэг илрүүлэх үндсэн чиг үүрэг бүхий байгууллага гүйцэтгэдэг, улмаар хэрэг илрүүлэх чиг үүрэгтэй байгууллага дотроо заавал “шүүхийн шинжилгээний алба”-д хамаарахгүйгээр үйл ажиллагаа явуулдаг байна.

<sup>32</sup> <http://www.nfs.go.kr:8080/engPR/statistics.action>

### ДҮГНЭЛТ

Шүүхээр аливаа хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд хууль, эрх зүйгээс гадна тусгай мэдлэгийн бусад салбарыг ашиглан үнэлэлт, дүгнэлт өгөх нь шүүхээс хууль ёсны, үндэслэлтэй шийдвэр гарах нэг гол хүчин зүйл болдог. Монгол Улсын хувьд шүүхэд шинжилгээ хийх тогтсон стандарт бүрэлдэн тогтоогүйгээс шинжилгээний дүгнэлтийн үнэн бодитой эсэхэд эргэлзээ төрөх, дахин шинжээч томилох, хуульчдын шинжээчийн дүгнэлтэд итгэх итгэл алдрах, шүүх шийдвэрийнхээ үндэслэл болгохгүй байх зэрэг бэрхшээл гарч байна. Тухайлбал, шинжилгээг шинжилгээний байгууллагаас гадуур хийлгэхэд дүгнэлт нь хуулийн шаардлага хангахгүй байх, шинжилгээ хийлгэх тогтоол, захирамжид заасан хугацаанд дүгнэлтээ гаргадаггүй зэрэг бэрхшээл тулгарч байна. Шинжилгээний тогтсон стандартыг бий болгосноор шинжээчийн дүгнэлт шинжлэх ухааны үндэслэлтэй, үнэн зөв гарах, шүүх шинжилгээний хүрээнд хэрэглэгддэг нэр томъёог нэг мөр болгон хэвшүүлэх, түүнчлэн шинжээчийн дүгнэлтийг үнэлэх үнэлэмж дээшлэх сайн талтай юм.

Шүүхийн шинжилгээний байгууллагын бүтэц, тогтолцоог боловсронгуй болгох санал, зөвлөмж дэвшүүлэх зорилгоор ХБНГУ, ОХУ, БНСУ болон Эстон Улсын шүүхийн шинжилгээний байгууллагуудын тогтолцоо, эдгээр байгууллагуудаас хийдэг шинжилгээний төрөлтэй харьцуулсан судалгаа. Дээр судалсан улс орнуудын шүүхийн шинжилгээний байгууллагуудын практикийг судалж, дараах дүгнэлтийг гаргалаа. Үүнд :

- Дээрх улс орнууд нь өөрийн гэсэн өргөн цар хүрээтэй шинжилгээний байгууллагатай байдаг.
- Шинжилгээний байгууллагуудын лабораториуд нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөний дагуу магадлан итгэмжлэгдсэн байна.
- Шүүхийн шинжилгээний үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудыг нутаг дэвсгэрийн хувьд бүсчилсэн байдлаар жигд хөгжүүлсэн байна. Ингэснээр цаг хугацаа, эдийн засгийн зардал хэмнэх, нэг газар, нэг шинжээчид ногдох ачаалал жигд хөгжсөн байна.
- Шинжилгээний байгууллагуудын үйл ажиллагааны үндсэн чиглэлд криминалистикийн шинэ багаж төхөөрөмж зохион бүтээх, эд мөрийн баримтыг судлах, шинжлэх арга технологийг боловсронгуй болгох болон бусад шинжилгээг явуулах зэрэг ордог.
- Криминалистикийн шинжилгээг дээр дурдсан байгууллагуудаас гадна цагдаагийн тусгай сургалтын байгууллага болон их дээд сургуулиудын тусгай лабораториор дамжуулан гүйцэтгэж болдог байна.
- Гадаад орны шинжилгээний байгууллагууд нь үйл ажиллагаандаа өндөр түвшний технологийг ашиглахаас гадна тоон систем бүхий хэрэгслийг хэрэглэх боломжтой байна.

Шинжилгээний туршлагын хувьд эдгээр байгууллагууд нь хроматограф, хэт ягаан туяа, цацраг идэвхт изотоп болон эдийн бүрэлдэхүүн болон бүтцийг задлан шинжлэх орчин үеийн аргыг хэрэглэж байна.

**САНАЛ, ЗӨВЛӨМЖ**

Энэ бодлогын судалгааны хүрээнд ХБНГУ, ОХУ, БНСУ болон Эстон Улсыг харьцуулан судалсны үндсэн дээр Монгол Улсын шүүхийн шинжилгээнд нэвтрүүлж болох дараах санал, зөвлөмжийг дэвшүүлж байна. Үүнд:

1. ОХУ, БНСУ-ын туршлагаас авч үзвэл “нутаг дэвсгэрийг бүсчлэн жигд хөгжүүлэх”.
2. Дараах шинжилгээний төрлийг Монгол Улсад бий болгох шаардлагатай байна. Үүнд:
  - Галын техникийн шинжилгээ;
  - Техник инженерийн шинжилгээ;
  - Бараа судлалын шинжилгээ;
  - Төмөр зам, агаарын-техникийн шинжилгээ;
  - Хүнс /хүүхдийн хоолны шим тэжээлийн шинжилгээг оруулаад/, тамхи, согтууруулах ундаа, согтууруулах бус ундааны шинжилгээ;
  - Газрын тосны бүтээгдэхүүний шинжилгээ;
  - Цацраг идэвхт бодисын шинжилгээ;
  - Сэтгэц судлал, сэтгэл судлалын шинжилгээ зэрэг болно. Эдгээр төрлийн шинжилгээг хийж эхлэхийн тулд хүний нөөц, боловсон хүчнийг энэ чиглэлээр бэлтгэх, шинжилгээнд тохирсон лабораторийн орчныг бий болгох нь тулгамдаж байна.
3. Эстон Улсын туршлагад тулгуурлан “Буруутай этгээдээс шүүхийн шинжилгээний зардлыг гаргуулах” тогтолцоог Монгол Улсад нэвтрүүлэх шаардлагатай байна. Ингэснээр шүүхийн шинжилгээний урсгал зардал болон бусад лабораторийн хөгжил, боловсон хүчний хангамжийг сайжруулах боломжтой юм.
4. ХБНГУ-ын туршлагад үндэслэн “шүүхийн шинжилгээний байгууллагыг бүсчлэн хөгжүүлэх”, хүний нөөцийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор хамтарсан сургалт, дадлага ажлыг тогтмол хийлгэж байх.
5. Шүүхийн шинжилгээний байгууллагын хуульд заасан үндсэн чиг үүрэг болох шинжилгээ хийж, дүгнэлт гаргах үйл ажиллагааг сайжруулах, ажилтнуудын ачааллыг хөнгөвчлөх, шинжээчийг гагцхүү шинжилгээ, судалгааны ажилд төвлөрч ажилладаг болгохын тулд Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн тогтолцоог шинэчилж, хэргийн газарт үзлэг хийхдээ нотлох баримт цуглуулах, зураг авах ажиллагааг гагцхүү хэрэг илрүүлэх үндсэн чиг үүрэг бүхий байгууллагуудаар хийлгэдэг болгох.
6. Дэлхийн улс орнуудын Шүүхийн шинжилгээний байгууллагууд өөрийн орны болон бүс нутаг, дэлхийн хэмжээний стандартчиллын байгууллагаар магадлан итгэмжлэгдсэн, ялангуяа хууль сахиулах байгууллагаас хамааралгүй, хөндлөнгийн, бие даасан шүүхийн шинжилгээний байгууллага, лабораториуд бүгд магадлан итгэмжлүүлсэн байна. Монгол Улсын Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуульд шүүхийн шинжилгээний лабораторид итгэмжлэл олгох талаар тодорхой заагаагүй боловч шүүхийн шинжилгээний зарим лабораториуд итгэмжлүүлэх шаардлагатай байна. Цаашид гадаад орны шүүх шинжилгээний стандартыг Монгол Улсад

нутагшуулан, магадлан итгэмжлүүлэх нь шинжилгээний чанар, үр дүн дэлхийн түвшинд хүрэх, бусад улсын шүүх шинжилгээний байгууллагатай хамтран ажиллах, дэлхийн болон бүс нутгийн шүүхийн шинжилгээний байгууллагын холбоонд гишүүнээр элсэх боломж бүрэлдэнэ.

7. Шүүхийн шинжилгээний уламжлалт төрлүүдээс гадна инженер техникийн, митохондрын ДНХ-ийн, хөрс, ургамал судлалын, эдийн засгийн шинжилгээний шинэ төрлүүд, материалын, хүнсний, газрын тосны, мэдээллийн технологийн, шүүх дижитал судлалын (компьютерын программ хангамж, электроник, гар утас судлал, цахим сүлжээ судлал), эмнэлэг-криминалистикийн, антропологийн, цацраг идэвхт бодисын, сэтгэц судлалын, тэсрэх төхөөрөмж, тэсрэх бодис, үнэр судлалын зэрэг лабораториудыг бий болгох шаардлагатай байна.
8. Шинжилгээ хийдэг, шинжилгээ хийхэд туслах үүрэгтэй оролцдог (лаборант, туслах ажилтан, бага эмч зэрэг) хүний нөөцийг нэмэгдүүлэх, хүний нөөцийн бодлого боловсруулан, төлөвлөгөө гарган мөрдөж ажиллах, шүүх шинжилгээ зүйн чиглэлээр боловсон хүчин бэлтгэх, Хууль сахиулахын их сургуульд нарийн мэргэжлээр шинжээч бэлтгэх боломжийг судлах зэрэг саналыг дэвшүүлж байна.

Дээрх судлагдсан нийт улс орнуудын шүүхийн шинжилгээний үйл ажиллагаанд чиглэсэн нийтлэг шинж нь газар нутгийн онцлог, хүн ам, эдийн засгийн хөгжил, гэмт хэргийн гаралт зэрэгтэй уялдуулан нутаг дэвсгэрийн шүүхийн шинжилгээний албыг бүсчлэн хөгжүүлсэн байна.



**-ХАВСРАЛТ-****ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГА, ШҮҮХИЙН ШИНЖЭЭЧИЙН  
ҮЙЛ АЖИЛЛАГАА, ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫГ ХУУЛЬД ТУСГАСАН НЬ**  
*/ТҮҮВЭРЛЭН АВАВ/***1. Цагдаагийн албаны тухай хуульд тусгагдсан байдал****4 дүгээр зүйл.Цагдаагийн албаны үйл ажиллагаа, удирдлагын үндсэн зарчим**

4.1.Цагдаагийн алба, алба хаагч нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хуульд зааснаас гадна хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, ил тод, нээлттэй байх, нууцыг чанд хадгалах, олон нийтийн итгэл хүлээж иргэний дэмжлэгийг авах, төрийн болон төрийн бус байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, иргэдтэй харилцан хамтран ажиллах, шинжлэх ухаан, орчин үеийн техник, технологи, мэдээллийн сүлжээний ололтыг ашиглах, нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх үндсэн зарчмыг баримтална.

**5 дугаар зүйл.Цагдаагийн байгууллагын тогтолцоо**

5.6.Цагдаагийн төв байгууллага нь гэмт үйлдлийг таслан зогсоох, гэмт этгээдийг аюулгүй болгох, баривчлах үүрэг бүхий тусгай бэлтгэл тактикийн бүлэг, тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр дагнасан шүүхийн шинжилгээний нэгжийг нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад байгуулан ажиллуулж болно.

**9 дүгээр зүйл.Гэмт хэрэгтэй тэмцэх**

9.1.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах зорилгоор хууль сахиулах ажиллагаа явуулахыг гэмт хэрэгтэй тэмцэх гэнэ.

9.2.Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн хүрээнд доор дурдсан эрх хэмжээг хэрэгжүүлнэ:

9.2.2.гэмт хэрэг, зөрчил гарсан тухай мэдээллийг хүлээн авмагц гэмт хэрэг, зөрчлийн газрыг хамгаалах, үзлэг хийх, нотлох баримт илрүүлэх, бэхжүүлэх, цуглуулах, гэмт этгээдийг олж тогтоох, эрэн сурвалжлах, баривчлах;

**13 дугаар зүйл.Цагдаагийн төв байгууллагын үүрэг**

13.4.3.энэ хуулийн 29.1-д заасан мэдээллийн сан үүсгэх, ашиглах, шинжилгээ хийх, дүгнэлт гаргах;

13.4.Гэмт хэрэгтэй тэмцэх нэгж энэ хуулийн 13.1-д зааснаас гадна доор дурдсан чиг үүргийн хүрээнд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

13.4.1.гэмт хэргийн газраас үл мөр, баримт сэлт илрүүлэх, цуглуулах, бэхжүүлэх, адилтгал хийх үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам, заавар, зөвлөмж боловсруулах, боловсронгуй болгох, биелэлтийг хангах;



**16 дугаар зүйл. Судалгааны төв**

16.1. Цагдаагийн байгууллагын судалгааны төв доор дурдсан чиглэлээр сан бүрдүүлэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажил явуулах, санал боловсруулах үүргийг хэрэгжүүлнэ:

16.1.2. гэмт хэргийн үл мөр илрүүлэх, бүүлган авах, бэхжүүлэх, нотлох, мөрдөн шалгах ажиллагааны арга тактикийг боловсронгуй болгох талаар;

**20 дугаар зүйл. Цагдаагийн төв байгууллагын даргын бүрэн эрх**

20.1.14. цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд шинжлэх ухаан, орчин үеийн техник, технологи, мэдээллийн сүлжээний ололтыг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах;

**21 дүгээр зүйл. Иргэний зөвлөл**

21.6. Иргэний зөвлөл доор дурдсан бүрэн эрхтэй байна:

21.6.2. цагдаагийн алба хаагчийн сургалт, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх үйл ажиллагаанд шинжлэх ухааны ололт, орчин үеийн техник, технологи, мэдээллийн сүлжээг нэвтрүүлэх бодлогын хэрэгжилтэд хяналт тавих;

**24 дүгээр зүйл. Олон нийтийн цагдаагийн ажилтан**

24.6. Олон нийтийн цагдаагийн ажилтан гэмт хэрэг, зөрчил гарсан газар, үл мөрийг хамгаалах, шаардлагатай этгээдийн баримт бичгийг шалгаж, оршин суугаа газрын хаягийг тогтоох, хэв журам сахих талаар иргэн, хуулийн этгээдэд шаардлага тавих, гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдийг түр саатуулах, цагдаагийн байгууллагад хүргэх эрхтэй.

**29 дүгээр зүйл. Үйл ажиллагаандаа тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сүлжээ, сан үүсгэж ашиглах**

29.1. Цагдаагийн байгууллага доор дурдсан тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сан үүсгэн, үйл ажиллагаандаа ашиглана:

29.1.20. гарын хээ, сүм, хонгио, генетикийн мэдээлэл;

**33 дугаар зүйл. Цагдаагийн алба хаагчийн эрх, үүрэг**

33.4. Цагдаагийн алба хаагч үйл ажиллагаандаа тэмдэглэл, илтгэх хуудас бичих, гар зураг үйлдэх, фото зураг авах, дүрс, дууны бичлэг хийх, полиграф ашиглах болон бусад арга хэрэглэнэ.

*Дээрхи зүйл, заалтуудын агуулга, үзэл баримтлалаас үзвэл цагдаагийн байгууллага тодорхой гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр дагнасан шүүх шинжилгээний албатай байхаар хуульчилжээ. Цагдаагийн байгууллага Эрүүгийн хуульд заасан 182 гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулдаг. Эдгээр гэмт хэрэг бүрийг маш олон төрлийн мөрөнд хийсэн шинжилгээгээр нотлох шаардлагатай. Гэтэл зөвхөн хэдхэн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр дагнасан цөөхөн лабораторитай шүүх шинжилгээний алба байх нь үр дүн муутай юм.*

## **2. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд тусгагдсан байдал**

### **57 дугаар зүйл. Шинжээчээр оролцож болохгүй байдал**

57.1. Шинжээч Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 16.1-д заасан үндэслэл байвал байцаан шийтгэх ажиллагаанд оролцож болохгүй.

### **155 дугаар зүйл. Шинжилгээ хийлгэх журам**

155.1. Шинжилгээ хийлгэхэд энэ хууль болон Шүүхийн шинжилгээний тухай хуульд заасан журмыг баримтална.

155.2. Шинжилгээ хийлгэх шаардлагатай гэж үзвэл хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх тогтоол, шүүгч захирамж гаргах бөгөөд шинжилгээ хийлгэх тухай тогтоол, захирамжид Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 7.2-т заасан зүйлийг тусгасан байна.

155.3. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч шинжилгээ хийх үед байлцах эрхтэй.

155.4. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч сэтгэцийн өвчний улмаас байдлыг ойлгох чадваргүй байгаа бол шүүх сэтгэцийн шинжилгээ хийлгэх тухай тогтоол, шинжээчийн дүгнэлтийг түүнд танилцуулахгүй байж болно.

155.5. Хууль хэрэглэх, хуулийн зүйл, хэсэг, заалтыг тайлбарлуулах асуудлаар шинжээч томилохыг хориглоно.

### **158 дугаар зүйл. Шинжилгээг шинжилгээний байгууллагаар хийлгэх**

158.1. Шинжилгээг шинжилгээний байгууллагаар хийлгэхэд Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан үндэслэл, журмыг баримтална.

### **160 дугаар зүйл. Харьцуулан шинжлэхээр хэв, хэлбэр авах**

160.3. Хэв, хэлбэр авах ажиллагааг шаардлагатай бол уг хэрэгт хувийн сонирхолгүй мэргэжилтнийг оролцуулан гүйцэтгэж болно.

160.4. Хэв, хэлбэр авах ажиллагааны тэмдэглэлийг энэ хуулийн 146, 154 дүгээр зүйлд заасан журмын дагуу үйлдэнэ.

### **161 дүгээр зүйл. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг эмнэлгийн байгууллагад шилжүүлэх**

161.1. Шүүх-эмнэлгийн, эсхүл сэтгэцийн эмгэг судлалын шинжээчийн дүгнэлт гаргахын тулд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг тодорхой хугацаанд эмнэлэгт байлгаж ажиглалт хийх шаардлагатай бол шинжээч томилох эрх бүхий этгээд энэ тухай үндэслэл бүхий тогтоол гаргаж хэрэгжүүлнэ.

161.2.Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг сэтгэцийн эмгэг судлалын эмнэлэгт шилжүүлэх бол прокурорын зөвшөөрөлтэйгээр гүйцэтгэнэ.

161.3.Сэтгэцийн эмгэг судлалын эмнэлэгт байсан хугацааг цагдан хоригдсон хугацаанд оролцуулан тооцно.

### **162 дугаар зүйл. Шинжээчийн дүгнэлтийн агуулга**

162.1. Шинжээч зохих шинжилгээ хийсний дараа дүгнэлт гаргана.

162.2.Шинжээчийн дүгнэлтэд Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан зүйлийг тусгасан байна.

162.3. Шинжилгээ хийж байх үед шинжээч уг хэрэгт ач холбогдол бүхий бусад зүйлийг олж тогтоосон бол энэ талаар асуулт тавигдаагүй ч байсан өөрийнхөө дүгнэлтэд заах үүрэгтэй.

162.4. Дүгнэлтийг бичгээр гаргаж шинжээч гарын үсэг зурах ба хэд хэдэн шинжээч дүгнэлт гаргахад оролцож нэгдсэн саналд хүрсэн бол нэг дүгнэлтэд, санал зөрсөн бол саналаа дүгнэлтэд хавсаргана.

### **163 дугаар зүйл. Шинжээчийг байцаах**

163.1. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх гаргасан дүгнэлтийг нь тайлбарлуулах буюу тодруулах зорилгоор шинжээчийг байцааж болно.

163.2. Шинжээч хариултыг өөрөө бичиж өгөх эрхтэй ба түүнийг байцаасан тэмдэглэлийг энэ хуулийн 146, 202 дугаар зүйлд заасан журмын дагуу үйлдэнэ.

### **165 дугаар зүйл.Нэмэлт ба дахин шинжилгээ хийх**

165.1.Нэмэлт ба дахин шинжилгээ хийлгэхэд Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 19, 20 дугаар зүйлд заасан үндэслэл, журмыг баримтална.

## **3. Тахарын албаны тухай хуульд тусгагдсан нь**

### **6 дугаар зүйл.Тахарын албаны чиг үүрэг, бүтэц**

6.7.Тахарын албаны шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх үндсэн бүтэц нь дараах чиг үүрэг бүхий нэгжтэй байна.

6.7.1.шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах;

6.7.2.гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах;

6.7.3.мөрдөн шалгах, эрэн сурвалжлах;

6.7.4.яллагдагч, ялтныг хуяглан хүргэх, нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах;

6.7.5.бусад нэгж.

### **17 дугаар зүйл.Мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах**

17.1.Тахарын алба дараах тохиолдолд мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулна:

17.1.1.шүүх, шүүгчийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг хэрэгжүүлэх;

17.1.2.оргон зайлсан яллагдагч, ялтныг эрэн сурвалжлах;

17.1.3.гэрч, хохирогч, тэдгээрийн хамаарал бүхий этгээдийг хамгаалах аюулгүй байдлын арга хэмжээг хэрэгжүүлэх.

### **36 дугаар зүйл.Мэдээллийн сан**

36.1.Тахарын алба нь хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд туслах тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сан, сүлжээ байгуулж ашиглана.

36.2.Тахарын албаны мэдээллийн сан нь төрийн нууцад хамаарна.

Тахарын алба нь зарим үүргээ хэрэгжүүлэхдээ шүүх шинжилгээний албатай хамтран ажиллах шаардлага тус хуулийн дээрхи заалтаас харагдаж байна.

## **4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд тусгагдсан байдал**

### **31 дүгээр зүйл. Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд шинжээч оролцох**

31.1.Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад мэргэжлийн тусгай мэдлэг шаардсан асуудлаар дүгнэлт гаргуулахаар шийдвэр гүйцэтгэгч өөрийн санаачилгаар, эсхүл оролцогч талын хүсэлтээр шинжээч оролцуулж болно.

31.2.Шинжээч нь мэргэжлийн байгууллага, эсхүл тухайн чиглэлээр мэргэжил эзэмшиж мэргэшсэн, уг хэргийн талаар хувийн болон албаны сонирхолгүй этгээд байна.

31.3.Шинжээч байгууллагаас томилогдсон бол тухайн байгууллагын, бусад шинжээч өөрийн нэрийн өмнөөс бичгээр дүгнэлт гаргаж, түүний үнэн зөвийг хариуцна.

31.4.Энэ хуулийн 31.3-т заасан дүгнэлтэд ямар шинжилгээ хийсэн, түүний үндсэн дээр гарсан дүгнэлт, шийдвэр гүйцэтгэгчийн тавьсан асуултад өгсөн үндэслэл бүхий хариултыг тодорхой бичнэ.

31.5.Шаардлагатай тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч хэд хэдэн этгээдийг шинжээчээр томилж болох бөгөөд тэдгээр нь санал нэгтэй байвал нэг дүгнэлт, санал нийлэхгүй байвал тус тусдаа дүгнэлт гаргаж гарын үсэг зурна.

31.6.Шинжээч шийдвэр гүйцэтгэгчийн дуудсанаар хүрэлцэн ирэх, тухайн асуудлаар үнэн зөв дүгнэлт гаргах, гүйцэтгэсэн ажлынхаа талаар тайлбар өгөх үүрэгтэй.

31.7.Шинжээчийн гүйцэтгэсэн ажлын хөлсийг шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлаас гаргана.

31.8.Дүгнэлт өгөхөөс татгалзах, зайлсхийх, эсхүл санаатайгаар худал дүгнэлт гаргасан бол Захиргааны хариуцлагын тухай болон Эрүүгийн хуулийн дагуу хариуцлага хүлээлгэхийг шинжээчид урьдчилан сануулна.

## **5. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тусгагдсан байдал**

### **59 дүгээр зүйл. Шинжээч**

59.1.Захиргааны хэрэг хянан шийдвэрлэхэд шинжлэх ухаан, тооцоо, тоо бүртгэл, урлаг, утга зохиол, техникийн зэрэг тусгайлан эзэмшсэн мэдлэгтэй, уг хэргийн талаар хувийн болон албаны сонирхолгүй, Шүүхийн шинжилгээний тухай хуульд заасны дагуу захиргааны хэргийн шүүхээс томилогдсон этгээдийг шинжээч гэнэ.

59.2.Нотлох баримтыг шинжлэх даалгавар авсан этгээд захиргааны хэргийн шүүхийн дуудсанаар хүрэлцэн ирж, тавигдсан асуудлаар бодитой дүгнэлт өгнө.

59.3.Шинжлүүлэхээр өгсөн материал хангалтгүй, эсхүл оногдсон үүргийг биелүүлэхэд эзэмшсэн мэргэжил, мэдлэг нь шаардлага хангахгүй гэж үзвэл шинжээч дүгнэлт өгөхөөс татгалзаж болно.

59.4.Шинжээч нь дүгнэлт өгөхөд шаардлагатай гэж үзвэл хэргийн материалтай танилцах, асуулт тавих, нэмэлт материал гаргаж өгөх тухай хүсэлтээ шүүхэд гаргах эрхтэй.

59.5.Санаатайгаар худал дүгнэлт өгсөн, эсхүл дүгнэлт өгөхөөс хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр татгалзсан шинжээчид Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

59.6.Шинжээч байгууллагаас томилогдсон бол тухайн байгууллагын нэрийн өмнөөс, бусад шинжээч өөрийн нэрийн өмнөөс дүгнэлтээ бичгээр гаргаж, түүний үнэн зөвийг хариуцна. Дүгнэлтэд ямар шинжилгээ хийсэн, түүний үндсэн дээр гарсан дүгнэлт, шүүгчээс тавьсан асуултад өгсөн үндэслэл бүхий хариултыг тодорхой бичнэ. Шинжээч хэрэгт ач холбогдол бүхий шинэ нөхцөл байдлыг олж тогтоовол энэ талаар шүүхээс асуулт тавигдаагүй ч гэсэн дүгнэлтдээ оруулах эрхтэй.

59.7.Шаардлагатай тохиолдолд шүүгч хэд хэдэн этгээдийг шинжээчээр томилж болох бөгөөд тэдгээр нь санал нэгтэй байвал нэг дүгнэлт гаргаж, гарын үсгээ зурна. Харин аль нэг шинжээч бусад шинжээчийн дүгнэлттэй санал нийлэхгүй байвал дүгнэлтээ тусад нь гаргаж болно.

59.8.Дахин шинжээч томилох тохиолдолд өмнө нь уг хэрэгт шинжээчийн дүгнэлт гаргахад оролцсон этгээд оролцохгүй.

## **6 .Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд тусгагдсан байдал**

### **47 дугаар зүйл. Шинжээч, түүний эрх, үүрэг, шинжээчийн дүгнэлт**

47.1.Хэрэг хянан шийдвэрлэхэд шинжлэх ухаан, тооцоо, тоо бүртгэл, урлаг, утга зохиол, техникийн зэрэг тусгай мэдлэг шаардагдах асуудлыг тодруулахын тулд хэргийн оролцогчийн хүсэлтээр шүүхийн санаачилгаар шүүгч захирамж гарган шинжээчийг томилно.

47.2.Шинжээч шинжилгээ хийж дүгнэлт гаргахдаа Шүүхийн шинжилгээний тухай хуульд заасан журмыг баримтална.

## **7.Төрийн албаны тухай хуульд тусгагдсан байдал**

### **8 дугаар зүйл.Төрийн тусгай албан тушаал**



8.1.Төрийн тусгай албан тушаалд Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд заасан журмын дагуу үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, хууль дээдлэх үндсэн зарчмыг сахиулах, нийгмийн хэв журмыг хамгаалахтай холбогдсон төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх дараахь албан тушаал хамаарна:

8.1.4. Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, цагдаагийн төв байгууллагын дарга, Хилийн цэргийн удирдах газрын дарга, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга, шүүхийн шинжилгээний байгууллагын дарга;

8.1.6. зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, тагнуул, цагдаа, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын байгууллагын офицер, ахлагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч, гаалийн байцаагч, шүүхийн шинжилгээний байгууллагын шинжээч, мэргэжилтэн;



**УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЗӨВЛӨМЖ****“ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТИЙН ТАЛААР АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ”  
(хэсэгчлэн авав)**

*Хоёр: Шүүхийн шинжилгээ хийлгэх буюу шинжээч томилсон шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийн талаар*

2.1. Шинжилгээ хийлгэх эсэхийг шийдвэрлэхдээ шүүх шинжээч томилуулах хүсэлтийг эрх бүхий этгээд гаргасан эсэх, хүсэлт ойлгомжтой тодорхой эсэх, хүсэлтэд заасан асуудлыг тодруулахад тусгай мэдлэг шаардлагатай эсэхийг заавал шалгаж байх нь зүйтэй. Үүнд:

2.1.1. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үе шатанд зөвхөн хэргийн оролцогч буюу Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д заасан этгээдийн бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн шүүгч захирамж, шүүх тогтоол гарган шинжээчийг томилно.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.3, Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д заасан шинжилгээ хийлгэхэд хэргийн оролцогчид заавал дахин хүсэлт гаргахыг шаардахгүй. Хэргийн оролцогчийн хүсэлтээр гарсан шинжээчийн дүгнэлт эргэлзээтэй, тодорхой бус эсхүл шинжээч зөрүүтэй мөн бүрэн бус дүгнэлт гаргасан, түүнчлэн шинжилгээтэй холбоотой шинэ нөхцөл байдал бий болсон тохиолдолд дахин болон нэмэлт шинжилгээ хийгддэг бөгөөд энэ нь шинжээч томилуулахаар урьд нь гаргасан хүсэлтийн дагуу хийгдэж буй ажиллагаа гэж ойлгох боломжтой гэж үзнэ.

Харин дахин шинжилгээ, нэмэлт шинжилгээг хийлгэхээр шүүх шинжээчийг томилохдоо Шүүхийн шинжилгээний хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, 20 дугаар зүйлийн 20.2-т заасан зөвшөөрсөн, хориглосон үндэслэлүүдийн талаар анхаарвал зохино.

2.1.2. Шинжилгээ хийлгэх тухай хэргийн оролцогчийн хүсэлтийг хангах эсэхийг захирамж, тогтоолд үндэслэл бүхий дүгнэсэн байх шаардлагатай. Хэргийн оролцогчийн хүсэлтэд дурдагдсан шинжилгээний объект, үйл баримтыг заавал тусгай мэдлэг бүхий этгээд тогтоох шаардлагагүй эсхүл хэрэгт авагдсан бусад нотлох баримтаар хангалттай тогтоогдсон гэж шүүх үзвэл хүсэлтийг хангахаас татгалзаж болно.

2.1.3. Хэрэв шүүх шинжилгээ хийлгэх буюу шинжээч томилох шаардлагатай гэж үзсэн бол шинжээчээр томилогдох этгээд нь шинжилгээ хийх тухайн асуудлаар “тусгай мэдлэг” бүхий эсэхэд шүүх анхаарах шаардлагатай юм. Шинжилгээний объектод буюу шинжлэгдвэл зохих зүйлийн талаар шинжлэх, дүгнэх асуудлыг зөв тодорхойлох, уг асуудлаар “тусгай мэдлэг” бүхий, мэргэжил эзэмшсэн этгээдийг шинжээчээр томилж байх нь зөв.

Түүнчлэн, хэргийн оролцогчтой ямар харилцаатай болохыг тогтоож, шинжээчээс татгалзан гарах үндэслэл байгаа эсэхийг шалгана. Шинжилгээ хийхэд харшлах шалтгаан байхгүй бол шинжээчид шинжилгээ хийлгэх тухай тогтоол, захирамж, хүсэлтийг гардуулан өгч, эрх, үүрэг, хариуцлагыг нь урьдчилан сануулж, гарын үсэг зуруулна.

2.1.4. Хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлогдвол зохих зүйл, үйл баримтын талаар /шинжилгээний объект/ оновчтой зөв асуултыг шинжээчид тавихын тулд хэргийн оролцогчийн хүсэл зоригийг тодруулах нь чухал. Хууль хэрэглэх, тодорхой зүйл,

хэсгийг тайлбарлуулах, мөн шүүхийн шийдвэрлэх эрх зүйн асуудлаар шинжээчид асуулт тавих нь буруу юм.

2.2. Шинжилгээ хийлгэх буюу шинжээч томилуулах тухай хэргийн оролцогчийн хүсэлтийг шүүх хангах эсхүл хэрэгсэхгүй болгож шийдвэрлэхдээ энэ тухай хүсэлт гаргаагүй бусад зохигчдод танилцуулсан байна.

2.3. Шүүх хүсэлтийг хангаж, захирамж, шүүхийн тогтоол гарган шинжээч томилсон тохиолдолд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1.8-д заасны дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлнэ. Ингэхдээ мөн хуулийн 71 дүгээр зүйлд заасан хэрэг хянан шийдвэрлэх ерөнхий хугацаатай шинжилгээ хийх хугацааг уялдуулан тогтооно.

2.4. Шүүхийн шинжилгээний байгууллагаас өөр этгээдийг шинжээчээр томилох шаардлагатай гэж шүүх үзвэл захирамж, тогтоол гаргахаас өмнө шинжээчээр томилогдох боломжтой этгээдийг дуудан ирүүлж, түүний мэргэжил, чадвартай танилцан, шинжилгээ хийлгэх асуудал нь түүний тусгай мэдлэгийн хүрээнээс хэтэрсэн, эсхүл шинжлэх ухааны арга, хэрэгсэл ашиглан хариулах боломжгүй нөхцөл байгаа эсэхийг тодруулна.

2.5. Шинжээчээр томилогдох этгээдийн талаар иргэний хэргийн оролцогч санал гаргах эрхтэй хэдий ч шүүх тухайн төрлийн “тусгай мэдлэг”-тэй холбоотой харилцааг зохицуулсан хууль тогтоомжийг үндэслэл болгон ямар байгууллага, мэргэжилтнийг шинжээчээр томилохыг шийдвэрлэх эрхтэй болно.

2.6. Шинжээчийг томилсон бол тогтоол, захирамж болон холбогдох баримтыг шүүхийн шинжилгээний байгууллагад хүргүүлж, томилогдсон шинжээчид эрх, үүргийг нь тайлбарлан өгч, дүгнэлт гаргахаас татгалзах буюу зайлсхийх, эсхүл санаатайгаар худал дүгнэлт гаргавал түүнд хүлээлгэх хариуцлагыг урьдчилан сануулж, гарын үсэг зуруулна.

2.7. Шүүх шинжилгээний цар хүрээ, онцлог, шинжлэгдэх объектын тоо хэмжээг харгалзан шинжилгээ хийх хугацааг үндэслэл бүхий тогтооно.

Тогтоосон хугацаанд дүгнэлт гаргах боломжгүй бол энэ тухайгаа шүүхэд мэдэгдэж, хугацаа сунгуулах журмыг шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд заах ба улмаар ямар үндэслэл, шалтгаанаар дүгнэлт хугацаандаа гарах боломжгүй болсон, цаашид ямар ажиллагаа хийгдэх шаардлагатай байгааг судлан үзсэний үндсэн дээр хугацаа сунгах эсэхийг шүүгч шийдвэрлэнэ.

2.8. Шинжээчид хүргүүлж буй шинжилгээний объектыг шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд нэрлэн заана. Хэрэв шинжлэгдэх объектыг шинжээчид хүргүүлэх боломжгүй бол түүнд чөлөөтэй нэвтрэх, шинжилгээ хийх нөхцөлийг хангах арга хэмжээг хэрхэн авахыг тодорхой тусгана.

*Гурав: Шинжилгээний зарим төрлийн талаар*

3.1. Хөрөнгийн үнэлгээ тогтоох:

3.1.1. Иргэн, хуулийн этгээд нь нарийн мэргэжил шаардах аж ахуйн зарим үйл ажиллагааг эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрлийн үндсэн дээр тогтоосон хугацаа, нөхцөл, шаардлагын дагуу эрхлэн явуулах бөгөөд үүний нэг нь хөрөнгийн үнэлгээ хийх ажиллагаа юм. Иймд тусгай зөвшөөрөлгүй этгээдийг шинжээчээр томилж хөрөнгийн үнэлгээний талаар дүгнэлт гаргуулах нь хуульд нийцэхгүйг анхаарвал зохино.

3.1.2. Үнэлгээчин үйлчлүүлэгчийн хүсэлтээр гэрээний үндсэн дээр хөрөнгийг үнэлэхээс гадна эрх бүхий этгээдийн шийдвэрээр үнэлгээ хийх талаар Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т заажээ.

Үйлчлүүлэгчийн хүсэлтээр гэрээний үндсэн дээр хөрөнгийн үнэлгээ хийвэл “үнэлгээний тайлан”, харин эрх бүхий этгээдийн шийдвэрээр үнэлгээ хийвэл “шинжээчийн дүгнэлт” гаргах бөгөөд эдгээр нь хоорондоо ялгаатай.

а/. Үнэлгээний тайлан:

Шүүхийн оролцоогүйгээр Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд хүсэлт гаргаж, хөрөнгийн үнэлгээ хийлгэх боломжтой бөгөөд энэ тохиолдолд “үнэлгээний тайлан” гаргадаг болно.

Үнэлгээний талаарх гомдлоо хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагын дэргэдэх Мэргэжлийн зөвлөлд гаргана.

Үнэлгээний тайлан нь шүүхийн тогтоол, захирамжийн дагуу гарсан шинжээчийн дүгнэлт биш тул уг баримтыг хэргийн оролцогчийн гаргасан бичгийн нотлох баримтын хэмжээнд үнэлэх нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, 44 дүгээр зүйлийн 44.1-т нийцнэ.

б/. Шинжээчийн дүгнэлт:

Шүүх шинжээч томилох замаар хөрөнгийн үнэлгээ тогтоох боломжтой. Хөрөнгийн үнэлгээний зүйл нь тодорхой үнэ цэнээр үнэлэгдэх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгө, бизнесийн үйл ажиллагаа, санхүүгийн өмчлөх эрх байна.

Үнэлгээчнийг шүүх шинжээчээр томилсон бол захирамж, тогтоолын дагуу шинжилгээний объектод хийсэн үнэлгээ нь шинжээчийн дүгнэлт болно. Дүгнэлт нь эд зүйлийн үнэ цэнэ, түүнийг тогтоосон үндэслэл, нотолгоог агуулсан үндсэн баримт бичиг бөгөөд дараах зүйлийг тусгасан байна. Үүнд: шинжээчийн нэр, хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл, түүний хугацаа, үнэлгээчний хариуцлагын даатгалын талаарх мэдээлэл; үйлчлүүлэгчийн нэр, хаяг, регистрийн дугаар болон шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл, хөрөнгийн үнэлгээ хийсэн үндэслэл, зориулалт, хөрөнгийн үнэлгээ хийсэн хугацаа болон тайлангийн он, сар, өдөр, хөрөнгийн үнэлгээний зүйлийн төрөл, түүний шинж байдлын тодорхойлолт, хөрөнгийн үнэлгээний зүйлийн өмчлөл, эзэмшил, ашиглалтын талаарх мэдээлэл хөрөнгийн үнэлгээний тайлангийн хамрах хүрээ, хязгаарлах нөхцөл, хөрөнгийн үнэлгээ хийхэд ашигласан баримт, мэдээлэл, нотолгоо, шинжилгээ, үнэлгээний тооцоолол, түүний үндэслэл, хөрөнгийн үнэлгээний зүйлийн үнэ цэнийг тогтооход хэрэглэсэн арга, горим, тэдгээрийн нийцтэй байдал, хөрөнгийн үнэлгээний зүйлийн тогтоосон үнэ цэнэ, хөрөнгийн үнэлгээг хуульд заасан стандарт, аргачлалын дагуу хийсэн талаарх үнэлгээчний мэдэгдэл зэрэг болно.

Хөрөнгийн үнэлгээ хийсэн шинжээчийн дүгнэлтийг эс зөвшөөрвөл энэ талаарх хүсэлт /гомдлоо/ шүүхэд гаргана. Шүүх хүсэлтийг нягтлан үзэж, шинжээчийн дүгнэлт эргэлзээтэй, тодорхой бус буюу үндэслэлгүй, эсхүл шинжээч зөрүүтэй дүгнэлт гаргасан бол Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.3, Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д зааснаар дахин буюу нэмэлт шинжилгээ хийлгэхээр шийдвэрлэж болно.

3.2. Хүүхдийн асрамж тогтоох хэргийг шийдвэрлэхэд хийгдэж байгаа шинжилгээ:

3.2.1. Хүүхдийг хэний асрамжид үлдээх талаар зохигчид харилцан тохиролцож чадаагүй бол шүүх эцэг, эхийн хүмүүжил боловсрол, амьдралын нөхцөл бололцоо, хүүхдийн

хүмүүжил, эрүүл мэндэд анхаарал, халамж тавьдаг эсэх, мөн хүүхдийг эд хөрөнгө, сэтгэл санааны дарамтанд байлгадаг, эрх чөлөөнд нь халдаж, эрүүл мэнд, сэтгэл санааны гэм хор учруулж байсан зэргийг харгалзан шийдвэрлэнэ. Түүнчлэн хүүхэд аюулгүй орчинд эрүүл саруул өсч, сурч боловсрох боломжийг анхааран үзэж, зохигчдын хэн нь дээрх шаардлагыг илүү хангаж байгааг харгалзан үзнэ.

3.2.2. Боловсролын тухай хуульд зааснаар боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага нь иргэд, олон нийтэд судалгаа, шинжилгээний мэдээллээр үйлчлэх, энэ төрлийн үйл ажиллагаа эрхлэхэд нь туслах, сургуулийн нийгмийн ажилтан нь суралцагч, эцэг эхийн нийгмийн асуудлаар үнэлгээ хийх, мэргэжлийн зөвлөгөө өгөх үүргийг тус тус хэрэгжүүлдэг. Иймд шүүх хүүхдийн асрамжийг шийдвэрлэхдээ дээрх байгууллага, мэргэжилтнийг шинжээчээр томилж, дүгнэлт гаргуулах нь хуульд нийцнэ.

3.2.3. Шүүхийн практикт хүүхдийн эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн болон төрийн бус байгууллага, мөн бүх шатны боловсролын байгууллага, сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч болон эмчийг шинжээчээр томилж, дүгнэлт гаргуулж байгааг буруутгах боломжгүй юм.

Хүүхдийн асрамж тогтоох хэргийг шийдвэрлэхэд хийгдэж байгаа шинжилгээ нь бусад шинжилгээнээс онцлогтой тул шүүх хэргийг шийдвэрлэхдээ дараах зүйлийг анхаарах шаардлагатай. Тухайлбал:

Хуульд заасан нөхцөл байдлыг тодруулахын тулд шинжээч зохигчид, тэдний эцэг эх болон шаардлагатай бусад хүмүүстэй уулзаж ярилцах, тайлбар авах, гэр оронд нь очиж амьдралын нөхцөл байдалтай танилцах зайлшгүй шаардлагатай бөгөөд энэхүү ажиллагааны үр дүнд дүгнэлтээ гаргадаг. Энэ нь Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5-д заасан шинжилгээг тал бүрээс нь бүрэн, бодитой, шинжлэх ухааны үндэслэлтэй хийх зарчмыг зөрчихгүй юм.

Харин шинжээч шинжилгээ хийж дүгнэлт гаргахдаа хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэн, нууцыг хадгалах зарчмыг мөрдлөг болгон ажиллах талаар шүүх тодорхой арга хэмжээ авч, энэ талаар шинжээчийн эрх, үүргийг танилцуулахдаа тайлбарлан өгсөн байвал зохино.

3.3. Зам тээврийн осол, хэргийн улмаас учирсан хохирол нэхэмжилсэн хэрэгт хийгдэж байгаа шинжилгээний талаар:

3.3.1. Тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүссэн гэм хорыг арилгах тухай нэхэмжлэлтэй хэргийг шийдвэрлэхэд осол, хэрэг гарахад хариуцагчийн гэм буруу тогтоогдсон байх нь чухал ач холбогдолтой.

Осол, хэргийн улмаас бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл, эс үйлдэхүйгээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй. Харин гэм хор учирсан нь өөрийнх нь буруугаас болоогүй гэдгийг нотолбол хуульд зааснаас бусад тохиолдолд гэм хор учруулсны хариуцлагаас чөлөөлөгддөг. Иймд энэ төрлийн хэргийг шийдвэрлэхэд зохигч өөрийн гэм буруугүй болохыг тогтоолгох зорилгоор шинжээч томилж дүгнэлт гаргуулах хүсэлт гаргадаг байна.

Зам тээврийн осол, хэрэг гарсан үед ихэвчлэн Цагдаагийн байгууллага хэргийн ул мөр болон ач холбогдол бүхий байдлыг тодруулах зорилгоор үзлэг хийж акт тогтоодог. Энэхүү акт шүүхээс томилогдсон шинжээчийн дүгнэлтэд тооцогдохгүй тул шүүх уг актыг бичмэл нотлох баримтын хэмжээнд үнэлэх нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, 44 дүгээр зүйлийн 44.1-д заасан зохицуулалттай нийцнэ.



*Дөрөв: Шинжээчийн дүгнэлт, түүнд тавигдах шаардлага, үнэлэх талаар*

4.1. Шинжээчийн дүгнэлт нь иргэний хэрэг хянан шийдвэрлэх явцад тусгай мэдлэг шаардагдах асуудлыг тодруулах зорилгоор шүүхээс томилогдсон мэргэжлийн байгууллага, тусгай мэдлэгийн хүрээнд тодорхой арга аргачлалын дагуу хийгдсэн, бодит үр дүнгээр хэмжигдэх цогц үйл ажиллагаа юм.

4.2. Шинжээч шинжилгээний явц, үр дүнг үндэслэн дүгнэлтээ бичгээр гаргаж, гарын үсгээ зурахын зэрэгцээ хувийн болон байгууллагын тамга, тэмдгээр баталгаажуулснаар хүчинтэйд тооцогдоно.

Харин шинжээч мэргэжилтний хувьд дүгнэлт гаргаж буй бол тухайн байгууллага, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.

4.3. Эрх бүхий этгээдийн шийдвэргүйгээр хийсэн шинжилгээ, дүгнэлтийг шинжээчийн дүгнэлт гэж үзэх, улмаар хуульд заасан арга, журмаар олж авсанд тооцох боломжгүй.

4.4. Дүгнэлтэд зарим шинжээч гарын үсэг зураагүй, тамга тэмдгээр баталгаажуулаагүй байвал шүүх энэ талаар тодруулж, шаардлагыг хангуулах арга хэмжээ авах нь хууль зөрчихгүй юм.

4.5. Шинжээчийн дүгнэлтийг хэргийн оролцогчдод танилцуулан, дүгнэлтийн талаар гаргасан хүсэлтийг тухай бүр шийдвэрлэж байх нь зүйтэй.

4.6. Шүүх шинжээчийн дүгнэлтийг хэрэгт авагдсан бусад нотлох баримттай харьцуулан үнэлнэ.

4.7. Шинжээчийн дүгнэлт бусад нотлох баримтаар давхар нотлогдоогүй бол түүнийг давууд үзэх, нотлогдсон тохиолдолд илүүд тооцох нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, 40.3-т нийцэхгүй юм. Шүүх шинжээчийн дүгнэлтийг шүүхийн шийдвэрийн үндэслэл болгож байгаа бол энэ тухай шийдвэрт тодорхой заасан байвал зохино.

4.8. Эрүү иргэн, захиргааны өөр хэргийн болон эрүүгийн хэргийг шалгах явцад гаргасан шинжээчийн дүгнэлтийг иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад зохигчийн хүсэлтээр гаргасан шинжээчийн дүгнэлтийн нэгэн адил авч үзэх нь буруу юм.

4.9. Шинжээч томилуулах хүсэлтэд дүгнэлт гаргуулахаар заасан үйл баримт шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр, тогтоолоор тогтоогдсон байгаа бол шүүх хүсэлтийг хэрэгсэхгүй болгох нь зүйтэй.

4.10. Шинжээч өөрийн гаргасан дүгнэлтийн үнэн зөвийг хариуцахаар Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4-д заасан тул захирамж, тогтоолоор томилогдоогүй этгээд дүгнэлт гаргах нь хуульд нийцэхгүй бөгөөд уг дүгнэлтийг шүүхээс томилогдсон шинжээчийн дүгнэлт гэж үзэхгүй.

4.11. Шинжээчийн дүгнэлт шинжилгээ хийлгэх зорилгод нийцсэн эсэхийг шүүх нягтлан, шаардлагатай бол шинжилгээг дахин хийлгэх эсэхийг шийдвэрлэж байх нь зүйтэй.

Жишээ нь: шүүх гэрээгээр гүйцэтгэсэн ажлын хэмжээ, түүний үнэлгээг тогтоолгохоор шинжээч томилсон бөгөөд шинжилгээний объект нь гүйцэтгэсэн ажил байхад /барьсан барилга, зам засвар г.м/ шинжээч шинжилгээний объектод шинжилгээ хийхгүйгээр зөвхөн нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, үйл ажиллагааны тайланг хянаж, дүгнэлт гаргасныг шүүх хүлээн авах нь шинжээч томилсон зорилгод нийцэхгүйг анхаарах нь чухал юм.

4.12. Шинжээчийн гол зорилго бол эрх бүхий байгууллагын тавьсан асуултад өөрийн мэргэжлийн ур чадвар, мэрэгжил, мэргэшлийг ашиглан хариулт өгөх явдал юм. Иймд шүүхээс асуулт тавиагүй байхад дүгнэлт гаргасан эсхүл шүүхийн тавьсан асуултад хариулаагүй бол шинжээчийн дүгнэлтийг Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт нийцсэн гэж үзэх хууль зүйн үндэслэлгүй болно.

Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.5-д зааснаар хэрэгт ач холбогдол бүхий шинэ нөхцөл байдлыг олж тогтоовол энэ талаар шинжээч дүгнэлтдээ тусгах хэрэгтэй бөгөөд энэ нь шүүхээс тавьсан асуултад шинжээч хариу өгсөн эсэхийг тогтоох ажиллагаанд хамааралгүй, хуульд заасан өөр зохицуулалт болохыг анхаарвал зохино.

4.13. Шинжээч дүгнэлт гаргахдаа ямар хууль тогтоомжийг үндэслэл болгосныг шүүх анхаарч энэ талаар дүгнэлт өгөх нь шүүхийн шийдвэр хууль ёсны байх шаардлагад нийцнэ.

Жишээ нь: Зохигчдын хооронд 2010 онд орон сууц худалдах, худалдан авах гэрээ байгуулагдсан ба уг гэрээний зүйл болох сууцны доторх хэмжээний талаар маргалдсан байна. Шүүх орон сууцны барилгын доторх сууцны хэмжээг тогтоохыг шинжээчид даалгасан бөгөөд шинжээч Барилга, хот байгуулалтын сайдын сайдын 2006 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 10 дугаар тушаалаар батлагдсан “Айлын сууцны талбайн хэмжээг тооцох журмыг үндэслэн” дүгнэлт гаргажээ. Гэтэл Барилгын тухай хуулийн /2008 онд батлагдсан/ 22 дугаар зүйлийн 22.1., 22.2.-т зааснаар барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан барилгын норм, нормативын баримт бичгийг заавал мөрдөх ёстой бөгөөд маргаантай сууцны талбайн хэмжээг зохигчдын гэрээ байгуулах үед даган мөрдөгдөж байсан журмын дагуу тогтоох учиртай байжээ. Зохигчдын гэрээ байгуулах үед “Орон сууцны барилгын доторх сууцны талбайг тогтоох тооцох аргачлал MNS 6058 2009” стандарт мөрдөгдөж байсан тул шинжээч хэрэглэвэл зохих хууль тогтоомжийг хэрэглээгүй тул шүүх нэмэлт эсхүл дахин шинжээч томилох ёстой байна.

4.14. Хэргийн оролцогч өөрийн хүсэлтээр аливаа мэргэжлийн байгууллагаар гаргуулсан тодорхойлолт, албан бичгийг шинжээчийн дүгнэлт гэж үзэхгүй. Шүүх эдгээрийг бичмэл нотлох баримтынх хувьд үнэлж, дүгнэнэ.